



**“ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН
ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙГ
ХЯНАН ШИЙДВЭРЛЭХТЭЙ
ХОЛБООТОЙ МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ТОГТООМЖ,
ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ
ХОХИРОГЧ ТӨВТЭЙ ХАНДЛАГЫН
ҮҮДНЭЭС ҮНЭЛЭХ НЬ”
СУДАЛГААНЫ ТОВЧ ТАЙЛАН**



Монгол улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг
бэхжүүлэх төсөл (2019-2022)

**“ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН
ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХТЭЙ
ХОЛБООТОЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ,
ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХОХИРОГЧ ТӨВТЭЙ
ХАНДЛАГЫН ҮҮДНЭЭС ҮНЭЛЭХ НЬ”
СУДАЛГААНЫ ТОВЧ ТАЙЛАН**

Улаанбаатар
2021 он

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО:

Гэр бүлийн хүчирхийллийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогч төвтэй хандлагыг хэрэгжүүлж буй байдалд үнэлгээ хийж, зөвлөмж гаргах.

СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ:


Судалгаанд гэр бүлийн хүчирхийллийн насанд хүрсэн хохирогчдыг хамруулсан. Ингэхдээ өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, уул уурхай төвлөрсөн орон нутгийн иргэд, хөдөөгийн болон суурин газрын орлого багатай эсвэл алслагдсан газрын/дүүргийн эмэгтэйчүүд, үндэстний цөөнх, хүйсийн цөөнх, эрэгтэй хохирогчид, дотоодын шилжин суурьшигчид зэрэг онцлог бүлгүүдийн асуудалд анхаарахаар зорьсон.

Судалгаа нь хамрах цаг хугацааны хувьд 2017 оноос хойш үйлдэгдсэн Гэр бүлийн хүчирхийллийн эрүүгийн хэрэг, зөрчлийг цагдаад бүртгэгдэх, шалгах, шийдвэрлэх явцад учирсан соёл, нийгэм, эдийн засаг, эрх зүйн, институтын болон тогтолцооны шинжтэй саад бэрхшээлүүдийг судалсан. Өөрөөр хэлбэл, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль хүчин төгөлдөр болсон 2017 оны 2 дугаар сараас хойш үүссэн хэрэг, тохиолдлыг судлах үүднээс 2018, 2019 оны хэргүүдийг хамруулсан.





Судалгаа Улаанбаатар хотын 4 дүүрэг, 4 аймгийг хамарлаа. Судалгааг явуулах газар нутгийг тодорхойлохдоо орон нутгийн хүн амын нийгэм, эдийн засгийн байдал ГБХ-ийг шийдвэрлэх ажиллагаанд ямар нөлөө үзүүлж байгааг илрүүлэх зорилгоор эмзэг буюу онцлог хүн амын бүлэг түлхүү оршин суудаг орон нутгийг хамруулахыг зорилоо. Үүнд: Архангай аймаг, олон ястны өлгий Ховд, гэмт хэргийн гаралт дээгүүрт ордог Төв аймгаас гадна ГБХ-ийн хэргийн тархалт бага, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв ажилладаг Дорноговь аймаг, Улаанбаатар хотод Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх дүүрэг, алслагдсан дүүргээс Налайх дүүргийг сонгон судаллаа.



Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхдээ эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх, хууль, дүрэм журмуудыг задлан шинжлэх, харьцуулах болон түүнчлэн хохирогч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг гүйцэтгэн явуулж байгаа цагдаа, прокурор, шүүгч нарын дунд социологийн судалгаа явуулах, баримт бичгийн судалгаа хийх, тодорхой кейс буюу хавтаст хэргийг түүвэрлэн судлах, тоо баримт цуглуулах, статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх, фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын аргыг хэрэглэсэн.

Баримт бичгийн шинжилгээний аргыг дараах байдлаар ашиглав: Үүнд:

- Гэр бүлийн хүчирхийллийн холбогдох үндсэн 6 хууль, 40 гаруй журам дүрэмд дүн шинжилгээ хийж, тэдгээрийн хийдэл, давхардал, хуулийн цоорхой, уялдаа холбоогүй байдлыг илрүүлэх;
- 2018, 2019 оны гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн талаар цагдаагийн байгууллагын статистик баримт мэдээ, прокурорын тайлан мэдээ, шүүхийн шийдвэр, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дүн мэдээнд шинжилгээ хийхэд баримт бичгийн шинжилгээний арга ашиглав.

Кейс судалгааны арга: Хавтас хэргийн судалгааг Монгол Улсын Архангай, Дорноговь, Ховд, Төв аймаг, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх дүүрэг, алслагдсан 3 дүүргээс Налайх дүүрэгт 2018-2019 онуудад шийдвэрлэгдсэн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг, шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн эрүү, зөрчлийн хэрэг, зөрчлийн хэрэгсэхгүй болсон хэргүүдийг хамруулсан. Хавтаст хэргийн судалгааг тоо болон чанарын хавсарсан аргыг ашиглаж явуулсан. Тухайлбал, тоон судалгааны аргыг ашиглан прокурорын байгууллагын цахим сангаас гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шалгаад хаасан, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсаны дараа мөрдөн байцаалтын хэргийг хэрэгсэхгүй болгосон, эсвэл яллах дүгнэлт үйлдэж шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн хэрэг, мөн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой зөрчлийн шүүхээр шийдвэрлэсэн болон хэрэгсэхгүй болгосон хэргийн судалгааг тоон мэдээллээр гаргаж тэр дундаас санамсаргүй сонгох аргыг ашиглан хэргийн дугаараар түүвэрлэж авсан. Харин чанарын судалгаагаар прокурорын байгууллагын цахим сангийн статистик тоо баримтыг үндэслэн хавтаст хэргийн судалгааны ажилд нийтдээ 139 зөрчлийн болон эрүүгийн хэргийг хамруулж унших, түүвэр хийх, үр дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийж зөрчлийн 59, эрүүгийн 80 хэргийг хамруулсан.

Фокус бүлгийн (ФБЯ) ярилцлагын арга: Практик үйл ажиллагааны мэдээллийг гүнзгийрүүлэн шалгах, учир шалтгааныг нь тодорхойлохоор цагдаагийн байгууллагын алба хаагч, прокурор, шүүгч, өмгөөлөгч, ТББ, ИНБ-ын нийт 209 хүнийг ФБЯ-д хамруулсан.

Статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх арга: Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн талаарх цагдаа, прокурор, шүүхийн статистик мэдээнд дүн шинжилгээ хийх аргыг ашиглав.

Хохирогчтой ганцаарчилсан ярилцлага хийх арга: Нийт 128 хохирогчтой ярилцлага хийсэн бөгөөд үүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон бэлгийн цөөнхийг хамруулсан.

Харьцуулах арга: Олон улсын гэр бүлийн хүчирхийллийн эсрэг баримт бичиг, үндэсний эрх зүйн зохицуулалт, туршлагыг судлахдаа харьцуулах аргыг ашиглаж, дүгнэлт хийв.

Судалгааг гүйцэтгэсэн баг:

Энэхүү судалгааг ОУХЭЗБ-ын төслийн нэгж олон улсын 1 зөвлөх, үндэсний 5 судлаачаас бүрдсэн баг гүйцэтгэлээ. Судалгааны багийн гишүүд нь мэргэжлийн хувьд хуульч 4, хүний эрх, жендэрийн эксперт 1, социологич 1 байлаа.

СУДАЛГААНЫ БАГИЙН ГИШҮҮД:

- Мартин Шкотцманс, судалгааны багийн ахлагч бөгөөд олон улсын зөвлөх
- Бираагийн Одонгэрэл, үндэсний ахлах зөвлөх бөгөөд эрх зүйн орчны шинжилгээ хариуцсан судлаач
- Лэгжээмийн Болор, хохирогчтой хийх ганцаарчилсан ярилцлага хариуцсан судлаач
- Шархүүгийн Солонго, бүлгийн ярилцлага хариуцсан судлаач
- Дангаагийн Нямбат, эрүү, зөрчлийн хэргийн үнэлгээ хариуцсан судлаач
- Гантөмөрийн Түвшинжаргал, баримт бичиг, мэдээллийн сан хариуцсан судлаач бөгөөд судалгааны туслах ажилтан.

ТОВЧИЛСОН ҮГ

ГБХТтХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ТББ	Төрийн бус байгууллага
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
УДШ	Улсын дээд шүүх
ХЗДХС	Хууль зүй дотоод хэргийн сайд
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
УИХ	Улсын их хурал
ЭХХШтХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЗШШтХ	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль

1. МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО, ТҮҮНД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

Монгол Улсад эмэгтэй, эрэгтэй хүмүүс тэгш эрхтэй болохыг хуулиар баталгаажуулсан төдийгүй бие биенийхээ эрхэнд халдахыг хориглосон¹ эрх зүйн орчин бүрдсэн. 2017 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль (ГБХТТХ)-ийг баталж, үүгээр гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг тусгайлан зохицуулсан. Шинээр батлагдсан энэхүү ГБХТТХ нь Монгол Улсад гэр бүлийн хүчирхийллийн төрлийг өргөжүүлж, үл хайхрах, гүтгэх, заналхийлэх, мөрдөн мөшгих зэргийг гэр бүлийн хүчирхийлэлд тооцохоор эрх зүйн хамгаалалтын хүрээг өргөтгөжээ. Түүнчлэн 2004 оны хуулиар тус хуулийн зохицуулалтад хамаарах этгээдийг Гэр бүлийн тухай хуульд заасан гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн хамаарна гэж иш татаж зохицуулсаныг өөрчилж, 2017 оны хуульд “энэ хуулийн үйлчлэлд эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээдээс гадна тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү болон гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд хамаарна” гэж өргөжүүлжээ.

Гэр бүлийн хүчирхийллийн тодорхойлолтыг өөрчилж, бие махбодын хүчирхийллээс гадна сэтгэл санааны, эдийн засгийн, бэлгийн зэрэг хүчирхийллийн хэлбэрийг хуульчиллаа. Эдгээр өөрчлөлт нь 2004 онд батлагдсан ГБХТТХ-ийн эрх зүйн хамгаалалтанд хамардаггүй байсан олон мянган хохирогчдод эрхээ хамгаалах боломжийг бүрдүүлсэн. Түүнчлэн ГБХТТХ-ийн 44 дүгээр зүйлд магадлан итгэмжлэгдсэн ТББ нь зан үйлд нөлөөлөх сургалт явуулах тухай гэр бүлийн хүчирхийллийн хохирогч үзүүлэх үйлчилгээг өргөжүүлж, хамгаалах байр ажиллуулах тусгайлсан журам баталж, үйлчилгээ нөхцөлийг сайжруулах заалтуудыг хуульчилсан. Эдгээр өөрчлөлт нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх эрх зүйн хамгаалалтыг өргөжүүлсэн сайн талтай.²

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван Зургадугаар зүйл, Гэр бүлийн тухай хуулийн 10.2, 10.3 дугаар зүйл, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4.1.2 заалт, Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл болон Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийг тус тус үзнэ үү.

² Бэгзсүрэн, Мэндизабал Жоффрэ, “Монгол Улсад эмэгтэйчүүдийн дуу хоолойг сонсож, бодитой ажил болгох нь” судалгааны тайлан 4.

ГБХТХ-ийн хэрэгжилтэд зохих дэмжлэг үзүүлэх, хууль хоорондын хийдэл, зөрчилтэй байдлыг арилгах үүднээс тус хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилттэй уялдуулан Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль зэрэг холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байдаг.³ Эрүүгийн хуульд оруулсан томоохон өөрчлөлт нь байнгын хүчирхийлэл, дарамтанд өртсөн хохирогч өөрийгөө хамгаалах аргагүй хамгаалалтын зохицуулалтыг хуульчлахын зэрэгцээ хүчирхийлэл, дарамтанд олон жил өртсөн хохирогч гэр бүлийн хүчирхийлэгчийг алсан бол өс хонзонгийн сэдэлтээр хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй зүйлчилж ялыг чангатгадаг байсныг өөрчилжээ.⁴ Үүнээс гадна, өмнөх эрүүгийн процессын хууль болох Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хохирогч ба хүчирхийлэл үйлдэгч хоорондоо эвлэрвэл хэргийг хэрэгсэхгүй болгох тухай заалт (25.1 дүгээр зүйл) байсныг шинэчилсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас хассан нь хохирогч гомдолгүй гэсэн хүсэлт гаргасан ч прокурор тус хэргийг үргэлжлүүлэн хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгосон юм.⁵

Дээрх өөрчлөлтийн үр дүнд Монгол Улсад гэр бүлийн хүчирхийллийн хэргийг хянан шийдвэрлэх эрх зүйн орчин сайжирсан гэж үзэж болохоор байна. Мөн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой дээрх эрх зүйн орчинг хэрэгжүүлэх үүднээс дээрх хуулиудыг дагаж 30 гаруй дүрэм журам батлагдсан. Монгол Улсын Засгийн газраас сум, хорооны төвшинд хамтарсан багийг байгуулах, хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн тоог нэмэгдүүлэх, ЦЕГ-т гэр бүлийн хүчирхийлээр мэргэшсэн хэлтэс, нэгжийг байгуулах зэргээр институцийн чухал бүтцийг бий болгосон. Хэдийгээр Монгол Улсад гэр бүлийн хүчирхийллийн эрх зүйн орчинг сайжруулах чиглэлд ийнхүү ахиц дэвшил гарч байгаа ч холбогдох хууль, дүрэм журамд дараах доголдолтой талууд байсаар байгаа нь гэр бүлийн хүчирхийлэлд хохирогч төвтэй арга хандлагыг хэвшүүлж чадахгүйд хүргэж байна. Дараах жишээгээр тодруулъя.

³ Ли́ла Сэ́йдман, “УИХ гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцох боллоо,” УБ пост сонин, 2016 оны 6 дугаар сарын 16-ны дугаар, Холбоос: <https://web.archive.org/web/20170422024344/http://theubpost.mn/2016/06/16/mongolian-parliament-recognizes-domestic-violence-as-a-criminal-offense/>.

⁴ Мөн дээрх эх сурвалжид.

⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он. <https://www.legalinfo.mn/law/details/12694>.

(I) “БАЙНГА” ГЭХ НЭР ТОМЬЁО НЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, НЭГДСЭН ТАЙЛБАРГҮЙ Тул ПРАКТИКТ НЭГ МӨР ОЙЛГОЛТГҮЙ, ТОДОРХОЙГҮЙ БАЙДЛЫГ БИЙ БОЛГОСОН.

Эрх зүйн зохицуулалтын хүрээнд:

Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг тодорхойлохдоо “Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэжээ. Өөрөөр хэлбэл, байнга үйлдээгүй бол зодох, харгис хэрцгий харьцах, догшин авирлах зэрэг дээрх хүчирхийлэл үйлдсэн үйлдлийг гэмт хэргийн шинжгүй гэж үзэж, Зөрчлийн тухай хуулийн үйлчлэлд хамруулдаг. Энэ нь гэр бүлийн хүчирхийллийн эхний 1, 2 удаагийн тохиолдлыг эрүүгийн гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж үзэж, зөвхөн баривчлах шийтгэл оногдуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгож байна. Зөрчлийн тухай хуулийн 5.4-р зүйлд гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодох, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадах, бусадтай харилцахыг хязгаарлах, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах үйлдэлд албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулахаар заажээ.⁶

“Байнга” үйлдэх шинж нь гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг гэж үзэхийн тулд хүчирхийллийн шинжтэй Эрүүгийн хуульд заасан үйлдлийг дахин давтан үйлдэх нөхцөлийг шаардана. Өөрөөр хэлбэл, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй үйлдлийг байнга буюу 3 удаагаас дээш үйлдсэн тохиолдолд гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалттай байна. Гэтэл энэхүү байнга гэсэн шинжийг тодорхойлсон Эрүүгийн болон бусад хуульд заасан тодорхойлолт, тайлбар байхгүй байна.

2017 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдахаас өмнө гэр бүлийн хүчирхийллийн нэг төрөл болох тарчлаах үйлдлийг Эрүүгийн хуулийн 100.1 дүгээр зүйл (тарчлаан зовоох гэмт хэрэгт)-д хуульчилсан ба энэ хүрээнд Улсын Дээд шүүхээс 2010 оны 5 дугаар сард 13 дугаартай тогтоол гаргаж, “байнга” гэдгийг гурван удаагийн тохиолдол гэж тайлбарласан. Тус

⁶ Зөрчлийн тухай хууль, 5.4 дүгээр зүйл.

хуулийн тайлбар гарах цаг хугацаанд 2002 оны Эрүүгийн хууль мөрдөгдөж байсан ба 2015 оны Эрүүгийн шинэчилсэн найруулгын хүрээнд 100.1 дүгээр зүйлийн тарчлаах гэмт хэргийг зүйлчлээгүй төдийгүй УДШ-ийн тайлбар ч шинэчлэгдээгүй. Эрүүгийн хууль болон бусад хуулиар тодорхойлсон эрх зүйн тайлбар байхгүйн улмаас цагдаа, прокурор, шүүхийн зүгээс 11.7 дугаар зүйлийн байнга гэсэн ойлголтыг 2010 оны 3 удаагийн тохиолдол гэсэн тайлбарын хүрээнд ойлгож байна.

Хэрэгжилт:

“Байнга” хэмээх үг дээр дурдсанаар 3 удаагийн тохиолдол гэсэн УДШ-ийн тайлбарын хүрээнд хэрэглэгдэж байгаа ч Эрүүгийн хуульд заасан тодорхойлолтгүй, нэг мөр ойлголтгүй байгаа нь гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хэргийг хянан шийдвэрлэх, яллахад хүндрэлтэй байдлыг үүсгэж буй нэг шалтгаан юм. Судалгааны багийн нийт 8 бүсэд хийсэн судалгаанд хамрагдсан хуульч, хууль сахиулагчид Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан байнга гэх нэр томъёог өөр өөрөөр тайлбарлаж, ашиглаж байгаа нь энэхүү ойлголт нэг мөр болохгүй байгааг дараах байдлаар харуулж байна. Тухайлбал, зарим дүүрэгт гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 3 тохиолдлын нэг нь хөнгөн гэмтэл учруулсан байхад “байнга” шинж хангагдсан гэж үзэж байгаа бол бусад газарт гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг бус зөвхөн хүний биед гэмтэл учруулсан гэж үзэн шийдвэрлэсэн байна. Түүнчлэн 24 цагийн дотор 3 удаа зодсон үйлдлийг нэг шалтгаанаар зодсон гэх үндэслэлээр байнга гэсэн шинжийг хангахгүй гэж үзсэн тохиолдол байна.

Байнга гэх шинж нь давталтын тооноос гадна гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрээс хамааран янз бүрээр хэрэглэгдэж байгааг судалгаагаар тогтоосон. Тухайлбал, гурван удаагийн хүчирхийллийн хэрэг нь адил хэлбэрийнх байх ёстой эсэх, эсвэл өөр шинжтэй байж болох эсэх, хэрэв тийм бол Эрүүгийн хуульд тусгайлан зааснаас гадна ГБХТТХ болон Зөрчлийн тухай хуульд тусгагдсан хэлбэрүүдийг нь тооцож үзэх эсэх нь тодорхойгүй хэвээр байна. Гурван тохиолдол нь тодорхой хугацааны (жишээлбэл, хуанлийн нэг жил) дотор үйлдэгдсэн байх ёстой эсэх, гурваас хойших тохиолдлыг цагдаад дахин мэдэгдэх, эсвэл шүүхийн шийдвэр гаргах шаардлагатай эсэх нь тодорхойгүй байна. УДШ-ийн 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний байнга гэсэн шинжийг хангахад Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулийн ижил шинжүүдээс давтагдаж буй

шинжүүдээр дүгнэлт хийх хүрээгээ тогтоож байх нь зөрчил ямар тохиолдолд гэмт хэрэгт шилжиж байгааг тодорхойлох хууль зүйн үндэслэл болно гэжээ. Хэдийгээр тийм боловч Зөрчлийн тухай хуулиар 3 удаа баривчлах шийтгэл хүлээсэн бол байнга гэсэн шинжид оруулан тооцож байгаа тохиолдол байгаа бол “нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна” гэсэн Эрүүгийн хуулийн зарчмыг баримтлан зөрчилд шийтгэл хүлээсэн тохиолдлыг эрүүгийн гэмт хэрэгт оруулан тооцохгүй гэж үзсэн тохиолдлууд ч байна.

Зөрчлийн тухай хуульд гэр бүлийн хүчирхийллийг зөрчилд тооцохдоо “байнга” гэсэн шинжийг агуулах шаардлагагүй тул нийт гэр бүлийн хүчирхийллийн хэргийн дийлэнх хувь нь Зөрчлийн хуулиар шийтгэгдэж байна. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн дагуу гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн нэг шинж болох “байнга” хэмээх үгийн хуулийн тодорхойлолттой холбоотой тодорхойгүй, хоёрдмол байдлын улмаас маш олон хэрэг зөрчлийн хэрэгт ангилагдаж, Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэгдэж байна. Хавтаст хэргийн судалгаанаас үзэхэд гэр бүлийн хүчирхийллийн давтамж нь цаг хугацааны хувьд үргэлж багассан байгаа нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч эхний үйлдэл гаргаснаас хойш дараа дараачийн хүчирхийллийн зай ойртсоноос нотлогдож байна. Өөрөөр хэлбэл, гэр бүлийн хүчирхийллийн эхний тохиолдол гарсан даруйд нь таслан зогсоох, дахин гаргуулахгүй арга хэмжээ авах нь цаашид хохирогчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалахад чухал ач холбогдолтой байна. Иймд “байнга” гэх шинжийг хангах нь гэмт хэргийн объектив талын бүрэлдэхүүнийг хангаж буй өнөөгийн эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн талаарх нэг мөргүй байдлыг нэн даруй шийдвэрлэх нь зүйтэй болжээ.

(II) ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ ХОЛБОГДОХ ХУУЛИУДАД ЯЛГААТАЙ БАЙГАА НЬ ХУУЛИЙН ЦООРХОЙ БИЙ БОЛГОЖ БАЙНА.

Эрх зүйн зохицуулалт:

ГБХТХ-ийн 5 дугаар зүйлд бие махбодын, сэтгэл санааны, эдийн засгийн болон бэлгийн хүчирхийлэл нь гэр бүлийн хүчирхийлэлд хамаарна гэж тодорхой заасан байдаг. Тус хуулийн 6 дугаар зүйлд сэтгэл санааны, эдийн засгийн, бэлгийн хүчирхийллийн янз бүрийн хэлбэрийг нарийвчлан авч үздэг. Тухайлбал, хуулийн 6.2 дугаар зүйлд бие махбодийн хүчирхийлэлд

амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан, эсхүл учруулж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүйг, 6.3-т сэтгэл санааны хүчирхийллийг хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгих, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэх үйлдэл багтахыг, 6.4-т эдийн засгийн хүчирхийлэлд цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах, орлого олох боломжийг нь хязгаарлах, шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах, эдийн засгийн хараат байдалд оруулсан, эсхүл санхүүгийн хохирол учруулах үйлдэл хамаарахыг, 6.5-д бэлгийн хүчирхийлэлд эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг ойлгоно хэмээн тус тус заасан.

Эрүүгийн хуулиар байнга зодох, харгис хэрцгий харьцах, догшин авирлах, тарчлаах, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах гэсэн ГБХ-ийн бие махбодийн, сэтгэл санааны, эдийн засгийн хэлбэрийг хуульчилсан бол Зөрчлийн тухай хуульд харгис хэрцгий харьцах, догшин авирлах, тарчлаах үйлдлийг хамруулаагүй бөгөөд зодох, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах үйлдлийг зааснаас гадна хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, бусадтай харилцахыг хязгаарласан гэсэн сэтгэл санааны хүчирхийллийг хуульчилжээ. Дээрх Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд эрх зүйн зохицуулалтын хувьд учир дутагдалтай, тодорхойгүй, хуулийн цоорхой үүсгэсэн дараах асуудлууд тулгамдаж байна.

- Эрүүгийн хуульд а. харгис хэрцгий харьцсан, б. догшин авирласан, в. тарчлаасан үйлдлүүдийг тодорхой хуульчилаагүй;
- Зөрчлийн тухай хуульд заасан бусадтай харилцахыг хязгаарласан, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан зэрэг зөрчлүүд нь Эрүүгийн хуульд хуульчлагдаагүй тул байнга үйлдэгдсэн байсан ч гэмт хэрэгт тооцож ял оногдуулах боломжгүй байдлыг бий болгож байна. Түүнчлэн хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан гэдэг үйлдлийг хэрхэн ойлгох талаар хуулийн тайлбаргүй тул нэгдмэл ойлголт байхгүй.

- ГБХТтХ-д эдийн засгийн хүчирхийллийг хүний цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах, орлого олох боломжийг нь хязгаарлах, шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах, тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдалд оруулсан, эсхүл эд хөрөнгийн хохирол учруулсныг хэлнэ гэж өргөн хүрээнд тодорхойлсон бол Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд “хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан” бол гэж хуульчилсан нь учир дутагдалтай болжээ.
- Бэлгийн хүчирхийллийн хэлбэрийг гэр бүлийн хамаарал бүхий хүнийг эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг бэлгийн хүчирхийлэл гэж ойлгоно гэж ГБХТтХ-д заасан. Харин бэлгийн хүчирхийллийн төрлийг Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуулийн 11.7-д огт гэр бүлийн хүчирхийлэлд тооцоогүй. Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн хүчиндэх гэмт хэрэгт “гэр бүлийн хамаарал бүхий хүнийг хүчиндсэн бол” хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй ял оногдуулахаар заасан ба бэлгийн хүчирхийллийн бусад хэлбэрийг гэр бүлийн хүчирхийлэлд хамруулаагүй.

Хэрэгжилт:

Гэр бүлийн хүчирхийллийн 4 хэлбэрийг Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд бүрэн гүйцэд, нэр томьёо тодорхой бус хуульчилсан нь дараах асуудлыг практикт бий болгож байгааг судалгаагаар тогтоолоо. Өөрөөр хэлбэл, хуулийн тодорхойлолтууд нь нэг мөр хэрэглэгдэх боломжгүй, бүрэн бус, янз бүр байгаагийн зэрэгцээ нэмэлт удирдамж, тайлбар байхгүй асуудал нь гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг тодорхойлж, хэлбэрүүдийг ялгаж ангилахад томоохон бэрхшээл дагуулж байна. Цөөн хэдэн чухал жишээг иш татаж үзье.

ГБХТтХ-д тодорхой хуульчилсан Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрүүд болох сэтгэл санааны болон бэлгийн хүчирхийлэл нь Эрүүгийн хуулийн гэр бүлийн хүчирхийллийн холбогдох заалтуудад ороогүй. ГБХТтХ-ийн дагуу гэр бүлийн хүчирхийллийн нэг хэлбэр гэж үздэг бэлгийн хүчирхийллийг Эрүүгийн хуулийн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 11 дүгээр зүйлд заагаагүй. Гэр бүлийн хүчирхийллийн нэг хэлбэр болох сэтгэл санааны хүчирхийллийг

Эрүүгийн хуульд огт оруулаагүй.⁷ Зөрчлийн тухай хуулийн 5.4-т заасан албадах, хязгаарлах, хүч хэрэглэх болон бусад арга хэлбэрийн үйлдлийг Эрүүгийн хуулийн гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрт оруулаагүйтэй холбоотойгоор Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд шаардсаны дагуу ийм үйлдлийг “байнга” давтан үйлдсэн ч гэлээ тэдгээр нь Эрүүгийн хуулийн үйлчлэх хүрээнд хамаарахгүй тул Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял завших боломжийг бүрдүүлжээ.

Жишээ нь: УДШ-ийн 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн тогтоолд “Энэхүү Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн объектив талын шинжүүдийг Зөрчлийн хуульд бүрэн зүйлчлээгүйгээс гэр бүлийн хүчирхийллийг байнга үйлдсэн гэх шинжийг хангахгүйгээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн шинжийг хангаагүй” гэж дурджээ. Тус тогтоолд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийн объектив талын үндсэн шинж нь “Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн”-ийг байнга: зодсон; харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан; хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан гэсэн 3 шинжийн аль нэгийг эсхүл хэд хэдэн шинжийг тус бүр байнга үйлдсэн байхыг шаардсан байх бөгөөд ... хохирогчийг “зодсон”, “хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах захиран зарцуулах эрхэд нь халдсан” гэсэн 2 зөрчлөөс бусад нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн шинжид хамаарахгүй байна гээд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний байнга гэсэн шинжийг хангахад дээрх хоёр хуулийн ижил шинжүүдээс давтагдаж буй шинжүүдээр дүгнэлт хийх хүрээгээ тогтоож байх нь зөрчил ямар тохиолдолд гэмт хэрэгт шилжиж байгааг тодорхойлох хууль зүйн үндэслэл болно гэж дүгнэсэн. Иймд 4 удаа Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар шийтгүүлсэн нөхцөл байдал нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т заасан гэмт хэргийн шинжийг хангахгүй байх тул анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзнэ гээд ... холбогдох хэргийг “Гэмт хэргийн шинжгүй” гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, түүнийг

⁷ Улсын Дээд шүүхээс 2010 оны 5 дугаар сард гаргасан 13 дугаартай тогтоолд тарчлаах гэдгийг “зовоон тарчлах шинжтэй” үйлдэл, “тарчлаах шинжтэй” гэдэгт бие махбодын болон сэтгэл санааны шаналгаа, өвдөлт үүсгэсэн аливаа үйлдэл хийхийг ойлгоно хэмээн тайлбарласан. Үүний нэгэн адил, зүй бус харьцах, харгис хэрцгий харьцсан гэдгийг хүнийг хууль бусаар хорих, бэлгийн хүчирхийлэлд оруулах, өлсгөх, цангаах болон махбодын болон сэтгэл санааны шаналгаа, өвдөлт үүсгэсэн аливаа үйлдэл хэмээн тайлбарласан.

цагаатгах нь зүйтэй гэж хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн дүгнэжээ. Энэ нь бидний судалгаагаар илрүүлсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн хэлбэрийг Эрүүгийн болон Зөрчлийн хуульд бүрэн хуульчилаагүй, хуулийн цоорхой бий болгосон гэсэн дүгнэлтийг бататгаж байна.

Цаашилбал, ГБХТХ-д заасан эдийн засгийн хүчирхийллийн тодорхойлолт нь Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд (хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах) зааснаас хамаагүй өргөн хүрээтэй хэдий ч мөн дээрхийн адил Эрүүгийн болон Зөрчлийн хуульд заасан хүрээнд практикт хэрэглэж байна. Түүнчлэн гэртээ агсам тавьж эд хогшлоо эвдсэн үйлдлийг эдийн засгийн хүчирхийлэлд тооцсон тохиолдол гарсан нь судалгаагаар тогтоогдсон гэх мэт. Иймд дээрх 2 хуульд заасан хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах үйлдлийг тодорхой томьёолох шаардлага байна.

(III) ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА ХОХИРОГЧ ТӨВТЭЙ ХАНДЛАГАНД СУУРИЛАХГҮЙ БАЙНА.

Эрх зүйн зохицуулалт:

Монгол Улс дахь гэр бүлийн хүчирхийллийн эрх зүйн орчин нь хохирогч төвтэй хандлагатай байгаа эсэхэд үнэлгээ хийх үүднээс гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэж байгаа эсэх, хохирогчид үзүүлэх үйлчилгээ, түүний төрөл, аюулгүй байдлын хамгаалал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тасралтгүй мэдээллээр хангагдах болон хууль зүйн туслалцаа авах боломж, хэрэгцээ, сонирхол, сэтгэл санаа, эдийн засгийн хувьд дахин хохироож болзошгүй бодлого, үйл ажиллагаа, хохирогчийг нөхөн сэргээх болон сэтгэл зүйн үйлчилгээ, нөхөн төлбөр авах, нотлох баримт бүрдүүлэхэд тулгарч буй саад, хөөн хэлэлцэх хугацаа дуусаж хэрэг хэрэгсэхгүй болох, хүчирхийлэгчид таслан сэргийлэх арга хэмжээ авах зэрэг олон асуудлууд тулгамдаж байна.

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан хохирогчид 1.аюулгүй байдлын хамгаалалт, 2.эмнэлгийн тусламж, үйлчилгээ, 3.сэтгэл зүйн үйлчилгээ, 4.нийгмийн халамжийн үйлчилгээ, 5.хүүхэд хамгааллын үйлчилгээ, 6.эрх зүйн туслалцаа, 7.холбон зуучлах үйлчилгээ гэсэн 7

төрлийн үйлчилгээ үзүүлэхээр хуульчилж, түүнчлэн дээрх үйлчилгээг үзүүлэх тусгайлсан журмуудыг ХЗДХС-ын тушаалаар нарийвчлан журамлаж хуулийн зохицуулалтыг хэн хэрхэн гүйцэтгэхийг заасан нь ач холбогдолтой болжээ. Дээрх 7 журмыг нарийвчлан авч үзэхэд эрх зүйн туслалцаа үзүүлэх журмыг зөвхөн насанд хүрээгүй хохирогчид эрх зүйн туслалцаа үзүүлэхээр журамласан нь нийт гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамруулж чадаагүй учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл, Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах талаар ЭХХШтХ, ЗШШтХ, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, Прокурорын тухай хууль гэсэн нийтлэг хуулиудад зааснаас гадна Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд Улсын ерөнхий прокурор хохирогчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран баталж, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авна” гэсний дагуу Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах тусгайлсан журам”-ыг баталсан хэдий ч тус журамд хохирогчид авах хамгаалалтын арга хэмжээний төрлийг тодорхой заагаагүй.

- Хохирогчид хамгаалалтын арга хэмжээ авах 2 нөхцөлийг хуульчилсан нь нэгдүгээрт, хохирогч өөрөө хамгаалалт авах гомдол мэдээлэл гаргасан бол хоёрдугаарт, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд заналхийлсэн, халдахаар завдсан, бэлтгэсэн, эсхүл халдлага бодитой эхэлсэн тохиолдолд хамгаалалт авах юм. Дээрх заалт нь хохирогчид хохирол учруулж болох хангалттай үндэслэл байгаа гэдгийг нотлоход цаг хугацаа шаардлагатайн дээр халдлага бодитой эхэлсэн байхыг шаардаж байгаа нь аюулгүй байдалд муугаар нөлөөлнө. Түүнчлэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар хохирогчид хамгаалалтын арга хэмжээ авахдаа харгалзан үзэх нөхцлүүдэд тухайн хохирогчийн болон олон нийтийн аюулгүй байдалд учирч болох эрсдэл, нөхцөл байдлын үнэлгээ, аюулын эрсдэлийн түвшин, хамгаалалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал, гэрч, хохирогчийн өгсөн, өгөхөөр зөвшөөрсөн мэдээлэл, нотлох баримтын ач холбогдол, хамгаалах арга хэмжээ хэрэглэх эсэхийг тодорхойлох сэтгэл зүйн сорилын үр дүн болон бусад нөхцөл гэсэн нь хохирогчид хамгаалалт авахад бий болгож буй эрх зүйн зохицуулалт нь хатуу нөхцөл байдлыг бий болгосон. Тухайлбал, тус хуулийн заалтаар гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн өгсөн мэдээлэл, нотлох баримтын ач холбогдлыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрхэн үнэлэх,

хамгаалалтыг хэрэглэх зардал өндөр гарах тохиолдолд хамгаалалтын арга хэмжээг авахгүй байх уу гэсэн асуултууд тодорхойгүй.

- ГБХ-ийн хохирогчийг түр хамгаалах байранд хамгаалалт авч болох ба ингэхдээ хохирогч болон түүний гэр бүлийн гишүүдэд аюулын зэргийн үнэлгээ хийж, түр хамгаалах байраар хангах тухай заажээ. Аюулын зэргийн үнэлгээг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 31.1 дүгээр зүйлд зааснаар цагдаагийн алба хаагч хийх ба Аюулын зэргийн үнэлгээ хийх тусгайлсан журам -ын дагуу хохирогчийн хүсэлт, цагдаагийн ажилтны хийсэн аюулын зэргийн үнэлгээ, нийгмийн ажилтны хийсэн нөхцөл байдлын үнэлгээ, хамтарсан багийн шийдвэр, хүүхдийг тусгай хамгаалалтаар хангах шийдвэрийг үндэслэн хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалуулах үүднээс түр хамгаалах байранд байрлуулдаг. Тус журмыг 2020 онд шинэчилсэн бөгөөд хэт нуршуу асуултаас сэргийлж, 20 асуулт асууж бөглөдөг байсныг 11 болгож багасгасаны дээр эхний 3 ноцтой асуултны аль нэгэнд тийм гэж хариулсан бол цааш асуултыг зогсоож хамгаалталтад авахаар заасан.
- Түр хамгаалах байрны стандарт -ын 4.4-т заасан түр хамгаалах байранд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч өөрөө ирсэн тохиолдолд баримт бичгийг шаардахгүйгээр хүлээн авсаны дараагаар цаашид хэр хугацаагаар байлгах асуудлыг тодорхой хугацаанд шийдэхээр заасан ч ЭХХШтХ, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд энэхүү заалт нь тусгагдаагүй байна.
- ЭХХШтХ болон ЗШШтХ-д хохирогчийн нийтлэг эрхэд хууль зүйн туслалцаа авах, тодорхой хүсэлт гаргах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, асуулт тавих, гомдол гаргах, хавтаст хэрэгтэй танилцах, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх зэрэг эрхүүдийг эдэлдэг. Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.3 дугаар зүйлд зааснаар мэдээллээр хангуулах эрхтэй ба прокурор, мөрдөгч нь хохирогчид зохих мэдээллийг 3-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ гэж заасан нь хохирогчийн мэдээллээр хангах эрхийг хангах заалт болжээ. Түүнчлэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар Сум, багийн засаг дарга, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн ажилтнууд хохирогчийг мэдээллээр хангах, тэдэнд үйлчилгээ үзүүлэх талаар хуульчилсан.

Хэрэгжилт:

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчилд хариуцлага хүлээлгэж, шийдвэрлэхэд хүндрэл учруулдаг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой дараах асуудлууд тулгамддаг. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийллийн хөөн хэлэлцэх хугацаа 6 сар байна. Энэхүү судалгаанаас үзэхэд хөөн хэлэлцэх хугацаа дууссаны улмаас олон хэрэг хэрэгсэхгүй болох хандлагатайг тогтоожээ. Хавтаст хэргийн судалгаанд хамруулсан хэргийн 4 хэрэг, зөрчлийн 1 нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон, 5 хэрэг зөрчил тутмын 1 нь хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хаасан байгаа нь нотлох ажиллагаа хангалттай явагдахгүй, мөрдөн шалгах ажиллагаа удаашралтай, эзэн холбогдогч нь тодорхой байсаар байтал эрэн сурвалжлах ажиллагаа хангалтгүй, АСАП санд эрэн сурвалжлах ажиллагааг зарлаагүйтэй холбоотой.

ЭХХШТХ-д зааснаар гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэргийг хуулийн дагуу цагдаагийн байгууллага эрүүгийн хэрэг үүсгэн, прокурорт шилжүүлэх болон шүүхээс хүчирхийлэл үйлдэгчид таслан сэргийлэх арга хэмжээ авахад шүүх эмнэлгийн гэмтлийн зэрэг тогтоосон нотлох баримтыг шаарддаг. Гэвч дийлэнх хохирогч уг шаардлагыг биелүүлэхэд хүндрэлтэй байсныг уг судалгаагаар тогтоожээ. Учир нь хохирогч гэмтэл нь эдгээгүй, ил харагдаж байхад шүүх эмнэлгийн магадлагаа авахын тулд 8000 төгрөгний (2.3 евротой дүйх) төлбөр төлөх, хол замд явах, лавлагаа авахад шаардлагатай материалыг бэлтгэх, ажлын цагийн хуваарьт нь тааруулж үйлчилгээ авах ёстой болдог. Хохирогч уг магадлагааг авах боломжгүй тохиолдолд гомдлыг цагдаагийн байгууллага эрүүгийн хэрэгт тооцож болох байсан ч нотлох баримтын наад захын шаардлага хангаагүй тул Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэдэг нь хүчирхийлэгч үйлдэгчийг өөгшүүлсэн ял завших боломжийг олгосон шийдэл болж байна.

Хохирогч эрүү, зөрчлийн хэргийг шалгаж дууссаны дараа хэргийн материалтай танилцах, тэр боломжоор хангагдах эрхийг хуульчилсан хэдий ч хэргийн материал танилцуулаагүй тохиолдолууд судалгаагаар илэрсэн. Гэхдээ хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэж байгаа тохиолдолд хохирогч хүсэлт гаргасан тохиолдолд танилцуулах эрхтэй болдог, зөрчлийн хэргийн хувьд нь хохирогч нь болж өнгөрч буй үйл явцыг нэгэнт мэдэж байгаа, холбогдогчтой хамт амьдарч байхыг үгүйсгэхгүй тул цагдаагийн байгууллага дээр ирж хэргийн материалтай танилцах шаардлагагүй гэж үзсэнтэй холбоотой зэрэг шалтгааны улмаас хохирогчийг эрхийг зөрчсөн

гэж шууд дүгнэх боломжгүй байна. Энэ нь хохирогч хэрэгсэхгүй болсон шийдвэрийг эс зөвшөөрч хохирогч хэн нь ч хяналтын прокурор болон дээд шатны прокурорт гомдол хүсэлт гаргаагүй байгаагаас харагдана. Харин зөрчил, эрүүгийн хэрэгтэй холбоотой гаргасан хүсэлт цагдаагийн байгууллага болон прокурорын шатанд бүрэн хангагдсан байна.

Түүнчлэн шүүх хуралдааны зарыг хохирогчид мэдэгдэх, тэрээр шүүх хуралд оролцох эрхтэй. Гэвч шүүх хурлын зарыг хохирогч талд мэдэгдээгүй тохиолдол илэрсэн, өмгөөлөгчгүй оролцсон тохиолдол нь өмгөөлөгчтэй оролцсон тохиолдлоос хавьгүй олон байгаа, ял шийтгэлийн төрөл хэмжээ болон хохирол нэхэмжлэлийн талаар нэг ч хохирогч хүсэлт гаргаагүй байгаа нь хууль эрх зүйн мэдлэг дутуу, өмгөөлөгчөөр хангагдаж чадахгүй байгаатай холбоотой хохирогчийн эрхийг зөрчсөн үйлдэл мөн. Хуулиар хохирогч хууль зүйн туслалцаа авах боломжтойг заасан хэдий ч энэ нь насанд хүрээгүй хүмүүсийн тухайд үйлчилдэг тул төлбөрийн чадваргүй насанд хүрсэн хохирогчид хууль зүйн туслалцаа авах эрх хангагдахгүй байгаа практикт түгээмэл байна.

Хохирогч өөрт учирсан хохирлыг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх эрхтэй. Гэвч хохирогчийн 91.8% нь эмчилгээний болон бусад зардалд мөнгө нэхэмжлээгүй байгаа нь гэр бүлийн хүчирхийллийн ихэнхи тохиолдол нь гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг тул гэр бүлийн орлого зарлага нь хэн хэнээсээ хамааралтай шалтгаанаар хохирогч эмэгтэйчүүдийн дийлэнх олонхи нь хохирол нэхэмжилдэггүй байх талтай. Түүнчлэн гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид хүчирхийлэгчээс нөхөн төлбөр авахаасаа илүүтэй хурдан салахыг бодох нь түгээмэл байдаг талаар судалгаанд оролцогчид хариулжээ. Бие махбодийн хохирол нэхэмжилсэн маш цөөн тохиолдол байгаа бол сэтгэл санааны хохирол нэхэмжилсэн, төлүүлсэн нэг ч тохиолдол байхгүй байгаа нь манай улсад сэтгэл санааны хохирол нэхэмжлэх, тооцоолох арга аргачлал байхгүйтэй шууд холбоотой практикт тулгамдаж буй асуудлын нэг мөн.

Хохирогчид бие махбодид нь халдаж цохиж зодсон ч гэмтэл учраагүй бол Зөрчлийн тухай хуулиар, хэрвээ хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учирсан бол Эрүүгийн хуульд зааснаар шийдвэрлэх бөгөөд мөрдөгч шинжээч томилж гэмтлийн зэргийг тогтоодог. Гэвч зодуулсан гэх зөрчлийн хэрэг хамгийн их бүртгэгдсэн байгаа нь хохирогч шүүх эмнэлэгийн дүгнэлт гаргуулах болон ирж очих замын зардалгүй, зодуулсан байдалтай гадуур явахаас санаа

зовох, өш хонзонгоос айх зэрэг олон шалтгаанаар шүүх эмнэлэгт үзүүлэлгүй гэмтлийн зэрэг тогтоолгохгүй татгалзсан нь судалгаагаар нотлогдож байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас эмнэлэгт хэвтэх шаардлагатай болтлоо зодуулж бие махбодид нь гэмтэл учирсан тохиолдолд ч хууль сахиулах байгууллагын алба хаагчид гэмтлийн зэрэг тогтоолгохгүйгээр хэргийг Зөрчлийн тухай хуулийн дагуу мөрдөн шалгаж, хариуцлага тооцох хандлагатай байна. Иймд төлбөрийн чадваргүй хохирогчийг үнэ төлбөргүй гэмтлийн зэрэг тогтоолгох боломжийг бүрдүүлэх, өмгөөллийн туслалцаа үзүүлэх нь хохирогч төвтэй хандлага төлөвшүүлэхэд чухал үндэслэл болох байна.

ЭХХШТХ, ЗШШТХ-д зөрчлийн хэргийн холбогдогчийг хэд хоногийн хугацаагаар баривчилсан, эрүүгийн хэрэгт яллагдагчийн цагдан хорьсон болон хорихоос татгалзаж байгаа шүүхийн шийдвэр болон хэргийг хаасан тохиолдолд энэ тухай хэн хэрхэн хохирогчид мэдэгдэж байх, ямар баримт үйлдэж баримтжуулах талаар хуулийн тодорхой заалт байхгүй байна. Мөн яллагдагч цагдан хоригдож байгаад батлан даалтанд гарах, эсвэл цагдан хоригдолгүй даалтанд гарсан тохиолдолд түүний хамгийн түрүүнд очих газар нь түүний гэр, үр хүүхэд нь бөгөөд энэ тухай урьдчилан мэдэгдсэн, яллагдагчид хүчирхийлэл үйлдэхгүй байхыг анхааруулсан эсэх зэрэг нь тодорхой биш байгаа нь хохирогчийг дахин хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, өөрийгөө болон гэр бүлийн гишүүдээ хүчирхийлэлээс хамгаалах, нүүх, тусламж дуудах, хамгаалах байранд очих, эрх зүйн туслалцаа авах хугацаа, боломжгүйд хүргэж байна.

(IV) ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИД ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ҮЙЛДЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ ТОГТОЛЦООНД ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ТҮЛХҮҮ БАРИМТАЛДАГ.

Дээр дурдсанаар мөрдөгч, хууль сахиулагч гэр бүлийн хүчирхийллийн хэргийг шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулиас илүүтэй ихэвчлэн Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг баримтлан холбогдогчийг захиргааны хэргийн зөрчилд хариуцлага хүлээлгэх хандлагатай байна. ЗШШТХ-ийн 1.8 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар Эрүүгийн хэргийн шүүх Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчилд шийтгэл оногдуулдаг

эрх бүхий ганц байгууллага юм. Гэвч уг судалгаагаар эрүүгийн хэргийн шүүхээс бусад эрх бүхий албан тушаалтан 2018, 2019 онд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийг шийдвэрлэсэн нь холбогдох заалтыг зөрчсөн байдлыг бий болгож байна. Энэ нь цагдаагийн алба хаагчид гэр бүлийн хүчирхийлэл хийх зан үйл, хандлагатай хүний үйлдэлд Зөрчлийн тухай хуулийн архидан согтуурах, олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, танхайрах зэрэг заалтыг баримтлах нь практикт түгээмэл байгааг нотолдог. Судалгаагаар гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн зүйлчлэл (5.1 дүгээр зүйл рүү шилжүүлсэн гэх мэт) өөрчлөгдсөнийг хохирогчид тайлбарлаж өгөөгүй тул тэд хэргийг цагдаагийн алба хаагч шийдвэрлэсэн гэж хариулсантай холбоотой байх боломжтой.

Онолын хувьд Зөрчлийн тухай хууль нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үр дүнтэй арга зам байж болох ч судалгаагаар эрх зүйн зохицуулалт болон түүний хэрэгжилтэд зөрүүтэй зүйлс байгаа нь тогтоогдсон. Тухайлбал, зүйлчлэл өөрчлөгдөхтэй холбоотой дээрх асуудал нь торгох, зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулах, албадлагын арга хэмжээ авах зэрэг хуульд заасан альтернатив шийтгэлийг оногдуулах боломжийг бий болгодог. Түүнчлэн шүүх баривчлах шийтгэлийг жирэмсэн эмэгтэй, арван дөрөв хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, эх, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүнд оногдуулахгүй⁸ гэсэн заалттай холбоотой торгох ялаар солих тохиолдол гардаг. Баривчлах шийтгэлийг үр нөлөө муутай тул бусад төрлийн шийтгэлийн төрлийг нэмэгдүүлэх нь зүйтэй гэж судалгаанд оролцогчид нэлээдгүй хариулсан байна.

(V) ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛД ОНОГДУУЛЖ БУЙ ЯЛ, ШИЙТГЭЛ НЬ ХЭТ ХӨНГӨН, ҮР НӨЛӨӨ МУУТАЙ БАЙНА.

Эрх зүйн зохицуулалт:

Эрүүгийн хуулийн тусгай ангид гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 7 төрлийн гэмт хэрэгт, Зөрчлийн тухай хуулиар 1 төрлийн зөрчилд шийтгэл оногдуулахаар хуульчилсан. Эрүүгийн хуулийн 7 гэмт хэрэг нь хөнгөн, хүнд гэмт хэргийн ангиллаас шалтгаалж торгох ялыг 450.000-14.000.000 төгрөгийн хооронд, нийтэд тустай ажил хийлгэх ял 240-720 цаг, хорих

⁸ Зөрчлийн тухай хуулийн 3.5 дугаар зүйлийн дэх хэсэг.

ялыг 6 сараас 20 жил болон бүх насаар нь хорих ял оногдуулахаар заасан байгаа нь гэр бүлийн хүчирхийллийг олон зүйл ангид тусган тодорхойлсон, хохирогч төвтэй, альтернатив хувилбар бүхий гэж үзэж болох байна. Гэсэн хэдий ч Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчилд албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулахаар заасан нь эсрэгээрээ шийтгэлийн хувилбаргүй, үр нөлөө муутай зохицуулалт болжээ.

Гэр бүлийн хүчирхийлэл анх удаа үйлдсэн тохиолдолд Зөрчлийн тухай хуулиар сануулах шийтгэл оногдуулах талаар ХЗДХЯ-аас санал илэрхийлж байсан.⁹ Энэ нь эерэг, сөрөг аль аль талыг дагуулах эрсдэлтэй. Тухайлбал, эхнэр, нөхрийн хооронд гэр бүлийн хувийн жижиг маргаанаас үүссэн асуудлаар ар гэрийн орлого олдог ганц хүнийг 30 хоног баривчлахаар гэр бүлээрээ шийтгэл хүлээж өрхийн орлого хумигдах эрсдэлтэй төдийгүй анх удаагийн түр зуурын уур уцаараас болсон асуудал хэсэг хугацааны дараа гэр бүл дотроо хэвийн харилцаа бий болж, шийдэгдэх боломжтой байдаг учраас сануулга өгдөг болох юм гэж зарим хуульчид үзсэн¹⁰ бол бидний судалгааны нэг хэсэг болох хавтаст хэргийн судалгаанд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч эхний тохиолдолдоо хөнгөн шийтгэл хүлээх нь дараагийн хүчирхийллийг үйлдэх сэдлийг төрүүлж, үйлдэл ойр ойрхон болж давтамж нь ойртдог байх магадлалтай гэж дүгнэсэн. Зөрчлийн тухай хуулиар баривчлах шийтгэлийн зэрэгцээ шийтгэлийн альтернатив хувилбарыг бий болгох нь зүйтэй байж болох ч энэ асуудлыг нухацтай судлах нь зүйтэй.

Хэрэгжилт:

Торгох, баривчлах шийтгэлийг гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт хамгийн түгээмэл оногдуулж байгааг судалгаагаар тогтоосон. Хохирогч, цагдаа, шүүгч зэрэг судалгаанд оролцогчдын зүгээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийг Зөрчлийн тухай хуулиар богино хугацаагаар баривчлах, торгох нь гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд үр нөлөөгөө өгөхгүй байгаад сэтгэл дундуур байгаагаар илэрхийлсэн. Зөрчлийн тухай хуулийн дагуу торгох нь эрүүлжүүлэх, танхайрахыг болиулахад чиглэсэн бөгөөд хохирогч өөрөөсөө эсвэл өрх гэрийн дундын хөрөнгөнөөс тухайн торгуулийг төлөх шаардлагатай болдог нь эргээд хохирогчид шийтгэл болох нь олонтаа. Түүнчлэн баривчлах шийтгэл эдлээд суллагдсан этгээд

⁹ П.Сайнзориг, Анх удаа гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдвэл сануулах арга хэмжээ авна. <http://itoim.mn/article/c8pKD/23754> 2020 оны 9 сар.

¹⁰ Мөн тэнд.

хохилогчид сэтгэл зүйн болон эдийн засгийн давхар дарамт учруулдаг. Энэ нь гэрч, хохилогчийг хамгаалах тогтолцоо Монгол Улсад алдагдсантай холбоотой. Өөрөөр хэлбэл, баривчлуулсан гэсэн үндэслэлээр хохилогчийг хүчирхийлэл үйлдэгч, түүний эцэг эх, ах дүү нь дарамталж, хонзогносон үйлдэл гаргаж, нөхцөл байдал улам дордсон талаар хохилогчид судалгаанд нэлээд дурджээ. Судалгаанд оролцсон хохилогчдын гурван хүний хоёр нь буюу 65.8% нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эхний тохиолдлоо цагдаагийн байгууллагад мэдүүлээгүй гэсэн байна. Учир нь цагдаад хэлээд нэмэргүй учраас мэдүүлэхийг хүсээгүй, хүчирхийлэгчийн дарамтнаас айсан гэж хариулжээ.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил үйлдсэн этгээдийг 7-30 хоног баривчлахын зэрэгцээ албадан сургалтад хамруулахаар хуульчилсан. Энэхүү сургалтыг хүчирхийлэгчийн зан үйлийг өөрчлөх, сэтгэл зүйн нарийн мэргэшсэн чиглэлээр явуулах нь зүйтэй боловч сургалтын чанар хангалтгүй байгаа нь судалгаагаар тогтоосон. Жишээ нь 461 дүгээр урьдчилан хорих төвийн сургалтын өрөө нь жижиг учраас сургалтанд бүх хүнийг хамруулах боломжгүйн зэрэгцээ багшлах хүний нөөц дутагдалтай, багш нар нь бэлтгэгдээгүй байдаг. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журмыг ХЗДХЯ-аас баталсан хэдий ч санхүүжилт хангалтгүйн улмаас дийлэнх сургалтын чанар хангалтгүй байна.

Зөрчлийн тухай хуулиар баривчлах шийтгэл оногдуулж байгаа нь гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоож чадахгүй байна. Учир нь баривчлах шийтгэл нь Эрүүгийн хуульд заасан бусад төрлийн ялаас хэт хөнгөн тул үр нөлөө муутай байна. Эрүүгийн хуульд заасан нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих зэрэг ялыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хөрөнгө санхүү, нарийвчилсан бусад зохицуулалт шаардлагатай байна. Мөн зохих хөрөнгө мөнгө байхгүйн улмаас зорчих эрхийг хязгаарлах шийтгэлийг дагаж мөрдөхөд хүндрэлтэй байдал бидний судалгаагаар нотлогдсон. Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хүчирхийлэгчийн зан үйл, хандлагыг өөрчлөх зан үйлд нөлөөлөх нийгэмд суурилсан хөтөлбөр гэхээсээ илүүтэй албадан хөдөлмөр эрхлүүлэх хүнд шийтгэл гэж хүлээн авдаг байна. Энэ байдал нь гэр бүлийн хүчирхийлэл давтан үйлдэхэд тодорхой нөлөө үзүүлдэг.

Эрүү, зөрчлийн хэрэгт оногдуулж буй ял, шийтгэлийн хэмжээ нь хуульд заасан дунджаас доогуур үзүүлэлттэй байна. Тухайлбал, Зөрчлийн тухай хуульд 7-30 хоног баривчлах шийтгэл оногдуулахаар заасан боловч

оногдуулсан шийтгэлийн дундаж 10.4 хоног байгаа нь 2018-2019 онд нийслэл хотын хэмжээнд баривчлах байр 1 байсантай холбоотой байх боломжтой. Судалгаанд хамрагдсан шүүхээр торгох, нийтэд тустай ажил хийлгэх, хорих ял оногдуулсан хэргүүд бүгд хуульд заасан ялын хэмжээний дунджаас доогуур ял шийтгэл оногдуулсан байгаа нь хууль тогтоох байгууллагаас гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй эрүүгийн хариуцлага нь хатуу чанга байхаар хуульчилсаны үр дүн гарахгүйд хүргэж байна. Иймд Монгол Улсад гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, гэмт хэрэгт ялын нэгдсэн бодлого үгүйлэгдэж байна.

2. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ЭСРЭГ АВЧ БАЙГАА ХУУЛИЙН БОЛОН БУСАД БАЙГУУЛЛАГЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улсын эрх зүйн орчин нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж буй цагдаа, прокурор, шүүгчид гэр бүлийн хүчирхийллийн мөрөөр арга хэмжээ авах, хүчирхийлэл үйлдэгчийг цээрлүүлэх, хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлсэн. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотойгоор авах боломжит хариу арга хэмжээ нь эрүүгийн санкц оноох, зөрчлийн шийтгэл оногдуулах, таслан сэргийлэх юм. Хэдийгээр зөрчлийн болон эрүүгийн шүүхийн тогтолцоо бүрэлдээд багагүй хугацаа өнгөрсөн ч гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хууль зүйн салбарын зүгээс зохистой арга хэмжээ авахгүй хэвээр байгааг судалгаа харуулж байна. Үүгээр ч зогсохгүй, гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт хамгийн ноцтой тохиолдолд л хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байна гэсэн дүгнэлтэд хүрч байна. Тодруулбал, 2017 оноос хойш хууль, шүүхийн байгууллагад шалгагдаж, шийдвэрлэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн тоо огт нэмэгдээгүй байна.¹¹

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Эрүүгийн хууль, ЭХХШТХ, Зөрчлийн тухай хууль, ЗШШТХ, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, эдгээр хуулиудын хүрээнд 30 гаруй журам үйлчилж байгаа нь эрх зүйн зохицуулалт сул гэж үзэхэд учир дутагдалтай боловч гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдал төдийлөн сайжраагүйн дээр эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтэд олон асуудал тулгамдаж байгааг судалгаагаар тогтоолоо.

Үүний цаана гэр бүлийн хүчирхийллийн талаар иргэдийн түгээмэл хандлага, ойлголт мэдлэг харилцааны талаарх ойлголт сул, холбогдох хуулиуд нь хоорондоо зөрчилддөг, ойлгомжгүй, хөрөнгө санхүү хязгаарлагдмал, хуулийн байгууллагын ажилтны ажлын ачаалал их, нарийн мэргэжлийн буюу мэргэшүүлэх сургалт хангалтгүй зэрэг олон шалтгаан байна. Хуулийн байгууллагын тогтолцооны уламжлалт хандлага нь гэр бүлийн харилцааны хүрээнд гэхээсээ бусад хүмүүсийн хүрээнд үйлдэгддэг хүчирхийлэлд анхаарч хэвшсэн. Харин энэ тогтсон үйл ажиллагаанд гэр бүлийн харилцааг оруулж ирсэн нь цагдаагийн алба хаагч, прокурор, шүүх болон бусад төрийн

¹¹ Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага, Суурь судалгааны тайлан.

байгууллагад олон бэрхшээл дагуулсан.

Монгол хүний уламжлалт соёлын улмаас гэр бүлийн асуудлаа дотооддоо хадгалах хандлагатай байдаг нь хохирогчийн гомдол гаргах хүсэл, хандлагад ч мөн илэрдэг. Гурван хохирогч тутмын хоёр нь гэр бүлийн хүчирхийллийн талаар цагдаа болон бусад эрх бүхий байгууллагад мэдэгдээгүй нь гэр бүлийн нэр хүндийг хамгаалах, гэр бүлийн хүрээнд асуудлаа шийдвэрлэхийг илүүд үздэг гэсэн үндсэн шалтгаантай болохыг судалгаагаар тогтоожээ. Цагдаад мэдэгдэхгүй байх өөр нэг шалтгаан нь хүүхдүүдээ дагуулаад очих газар байхгүй хэмээн айдагтай холбоотой. Түүнээс гадна, хохирогч гомдол гаргасан ч гэсэн ярилцлагад хамрагдсан хохирогчдын 60-70 хувь нь гомдлоо буцааж авна гэж хариулсан байна. Хохирогчид гомдол гаргаж шийдвэрлүүлэх нь урт хугацаанд үргэлжлэх, хүндрэлтэй үйл явц бөгөөд хууль шүүхийн байгууллагын алба хаагчдын тэдэнд хандаж буй хандлага, хүчирхийлэгчийн зан үйлд эерэг нөлөө бодитойгоор гарахгүй байгаад сэтгэл дундуур байна. Ихэнх тохиолдолд цагдаагийн алба хаагчийн авч буй арга хэмжээ нь хүчирхийлэл үйлдэгчийг баривчлан саатуулахаас илүүтэй одоо болж буй хүчирхийллийг тэр даруй таслан зогсооход чиглэдэг бөгөөд энэ нь хүчирхийлэгчийг уурлуулж, суллагдсаныхаа дараа “өшөө авах үүднээс” хохирогч руу халдахад хүргэх эрсдэлийг дагуулдаг гэж хохирогчид хариулжээ.

Энэхүү товч тайланд дурдсан Монгол Улсын гэр бүлийн хүчирхийллийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хэргийг хууль шүүхийн байгууллагын шат дарааллаар шийдвэрлэх байдлыг сайжруулах шаардлагатай байгааг уг судалгаа тогтоосон. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хуулийн байгууллагуудын хариу арга хэмжээ цагдаа, прокурор, шүүх гэсэн хэсэгтэйгээр авч үзье.

1. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА

Цагдаагийн байгууллага нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхний үе шат бөгөөд судалгаанд хамрагдсан хохирогчдын 83.3 хувь нь цагдаагийн байгууллагыг гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, хохирогчийг хамгаалах эрх бүхий гол байгууллага хэмээн тодорхойлсон байна. Гэр бүлийн хүчирхийллийн ихэнх тохиолдолд хүний бие махбодид ноцтой гэмтэл учруулахыг таслан зогсоох үүднээс цагдаа дууддаг. Цагдаагийн алба хаагчид нь зохих арга хэмжээг хамгийн түрүүнд авах хүмүүс байдаг ч зохих сургалтад бага хамрагдсан, хөрөнгө нөөц хангалтгүй, гэр бүлийн

хүчирхийлэл гэж юу болох талаар явцуу үзэл бодол нь гомдлыг цаг тухайд нь нухацтай авч үзэх, бүртгэх, шалгахад нь саад болох талтай байдаг. Энэхүү судалгаагаар гурван хохирогч тутмын нэг нь л гэр бүлийн хүчирхийллийн талаар цагдаагийн байгууллагад гаргасан гомдол нь хууль хяналтын байгууллагаар бүрэн шийдэгдэж, эерэг нөлөөг нь мэдэрсэн гэж хариулжээ. Харин дийлэнх хохирогчийн хувьд гэр бүлийн хүчирхийлэл тулгарсан хэвээр байгаа буюу цаашлаад нөхцөл байдал улам дордсон байна. Ийм учраас хуулийн байгууллагууд, тэр дундаа цагдаагийн байгууллагын одоо авч буй хариу арга хэмжээ нь гэр бүлийн хүчирхийллийн дийлэнх хохирогчдын хувьд эерэг үр нөлөө авчрахгүй байна гэж энэхүү судалгаагаас дүгнэж болно. Цагдаагийн байгууллагын зүгээс гэр бүлийн хүчирхийллийн дуудлага хүлээн авах, гомдол хянан шийдвэрлэх байдал, аюулын зэргийн үнэлгээ хийх, гомдол мөрдөн шалгах, хохирогчтой харилцах байдал зэрэг олон зүйлийг сайжруулах шаардлагатай.

Хохирогчид зөвхөн бие махбодын хүчирхийллийн талаар л цагдаад мэдэгддэг, хүчирхийлэл нь тэвчихийн аргагүй эсвэл амь насанд аюултай болсон үед л ханддаг

Энэхүү судалгаагаар Монгол Улсын хэмжээнд 2019 онд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн шинжтэй 57,749 дуудлага цагдаагийн байгууллагад иржээ. Цаашлаад, энэхүү судалгаанд хамрагдсан гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын дийлэнх нь (76.6 хувь) өөрсдөө шууд цагдаад мэдэгдсэн. (нийгмийн бусад үйлчилгээтэй харьцуулж үзнэ үү). Онцлон дурдахад, хохирогчдын хамгийн их өртсөн гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр нь сэтгэл зүйн буюу сэтгэл санааны хүчирхийлэл (90 хувь) бол удаах нь бие махбодын хүчирхийлэл (71.7 хувь), мөн эдийн засгийн хүчирхийлэл (55.8 хувь) байна. Хүчирхийлэл үйлдэгчдийн дийлэнх олонх нь (96.7 хувь) нь эрэгтэй байна. Хохирогчид гэр бүлийн хүчирхийллийн бусад хэлбэрт (жишээ нь, сэтгэл санааны, эдийн засгийн гэх мэт) өртсөн үед цагдаад шууд ханддаггүй, гэр бүлийнхнээсээ тусламж авахыг илүүд үздэг гэж хариулжээ.

Судалгаанд оролцсон ихэнх хохирогчид гэр бүлийн хүчирхийллийн хэд хэдэн хэлбэрт зэрэг өртөж байсан ч ихэнх хохирогч бие махбодын ноцтой хүчирхийлэлд өртсөн (өөрөөр хэлбэл, бие махбодид нь хүнд гэмтэл учруулсан, хүчирхийллийг тэвчихийн аргагүй болсон) үед л цагдаад ханддаг байна. Нас тогтсон, хөдөө орон нутагт амьдарч буй хохирогчидтой

харьцуулахад нас залуу, Улаанбаатар хотод оршин суудаг хохирогчид цагдаад мэдэгдэх нь түгээмэл хандлагатай боловч ийнхүү мэдэгдэж буй гол зорилго нь өөрт нь тохиолдож буй бие махбодын хүчирхийллийг зогсооход оршиж байна. Тодруулбал, судалгаанд хамрагдагсдын 73.4 хувь нь цаашид тэвчих аргагүй болсон, 76.6 хувь нь маш хүнд бэртсэн тул амиа алдахаас айж тусламж хүссэн гэж хариулжээ. Судалгаанд оролцсон гурван хүн тутмын нэг нь нэмж хүчирхийлүүлэхээс эмээж, түүнийг зогсоохын тулд цагдаад хандсан байна. Тэгэхээр хүчирхийлэл давтан үйлдэх нь хэвшил болж, бие махбодын гэмтэл ноцтой болсон үед л цагдаа оролцдог байна. Энэ нь гэр бүлийн хүчирхийллийн тухайд цагдаад өгсөн бүх гомдол, мэдээллийг нухацтай авч үзэх ёстой гэсэн үг. Учир нь дийлэнх тохиолдолд хохирогч эцсийн хүнд шатанд л цагдаад ханддаг гэсэн хариулт бол хохирогчийн гомдол хэр ноцтойг харуулж байна.

Цагдаагийн анхан шатны хариу арга хэмжээ шуурхай байгаа боловч гэр бүлийн хүчирхийлэл, ялангуяа бие махбодын хүчирхийллээс бусад хэлбэрийн талаар ерөнхийдөө ойлголт дутмаг байгаа нь харагдаж байна.

Яаралтай хариу арга хэмжээ авах тухайд цагдаа дуудлага хүлээн авснаас хойш нийслэл болон орон нутагт 24 цагийн дотор очиж, таслан зогсоодгийг уг судалгаагаар тогтоосон. Энэ нь ЦЕГ-ын мэдээллийн сан болон цагдаад мэдэгдсэн оролцогчдын 87.8 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн бараг бүх тохиолдлын хувьд мэдэгдсэн өдөрт багтаж цагдаагийн алба хаагч хэргийн газар ирсэн гэж хариулснаас батлагдаж байна. Энэ нь ихэнх тохиолдолд цагдаа гэр бүлийн хүчирхийллийн тухай мэдээлэхэд цаг алдалгүй арга хэмжээ авдаг гэсэн үг бөгөөд энэ нь хууль сахиулах байгууллагын алба тушаалтны үүрэг хариуцлага, ГБХТХ-ийг гаргахад төсөөлсөн баримтлалтай нийцэж байна.

Дуудлагаар ирсэн цагдаагийн алба хаагч аюулын зэргийн үнэлгээ хийх шаардлагатай бөгөөд аюулын түвшинг тодорхойлж, түүнээс ("бага", "дунд", "их") хамаарч гэр бүлийн хүчирхийлэлд зохих арга хэмжээ авдаг. Цагдаагийн алба хаагчид хэргийн газарт очоод ямар арга хэмжээ авсан талаар асуухад судалгаанд хамрагдагсдын зөвхөн 42.2 хувь нь ирсэн цагдаа аюулын зэргийн үнэлгээ хийсэн гэж хариулсныг анхаарах нь зүйтэй. Аюулын зэргийн үнэлгээ хийгээгүй тохиолдлын тоо, хийгээгүй шалтгаан нь ЦЕГ-ын мэдээллийн

санд бүртгэгддэггүй. Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр, хохирогчийн бие махбодид учруулсан гэмтэл гэх мэт нэмэлт мэдээллийг ЦЕГ-ын мэдээллийн санд бүртгэдэггүй бөгөөд эдгээр мэдээллийг зөвхөн хэргийн материалаас л олж үзэх боломжтой. Хэдий аюулын зэргийн үнэлгээ шаардлагатай боловч хохирогчийн сэтгэл зүйн эмгэгт мэдрэмжтэй байдлаар хийгддэггүй бөгөөд ихэвчлэн дахин хохирогч болсон мэдрэмж төрүүлэх нөлөөтэй байдаг байна.

Судалгаанд хамрагдагсдын дийлэнх буюу 88.6 хувь нь цагдаагийн алба хаагч гомдлыг нь бүртгэсэн гэж хариулсан боловч энэ судалгаагаар гомдол гаргаснаас мөрдөн байцаалт эхлэх хүртэл дунджаар 2.9 (3 орчим) хоног буюу 69.6 цаг зөрүүтэй байгааг тогтоосон. Энэ нь хохирогчийн аюулгүй байдал, дахин хохирох эрсдэл зэрэгт тодорхой хэмжээнд нөлөөлж байна.

Цагдаагийн алба хаагчид гэр бүлийн хүчирхийллийг голчлон бие махбодын хүнд гэмтэл, бие махбодын хүчирхийллийн хэмжээнд ойлгосон хэвээр байна.

ГБХТХ-д гэр бүлийн хүчирхийлэл нь бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны болон эдийн засгийн хүчирхийллийн хэлбэртэй байна гэж онцлон заасан хэдий ч дээрх гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрүүд хохирогчдын буюу хууль сахиулах байгууллагынхны хандлага, ойлголт, практикт хараахан бүрэн хэмжээнд хэрэгжихгүй байгаа нь ажиглагдлаа. Энэхүү судалгаагаар цагдаа зөвхөн бие махбодын хүчирхийлэл, эдийн засгийн зарим хүчирхийлэл (хулгай, эд хогшлоо эвдэх гэх мэт)-д анхаарлаа хандуулдаг болохыг тогтоожээ. Гэвч хохирогч нүдэнд харагдахуйц гэмтэл авсан тохиолдолд л цагдаагийн алба хаагчид бие махбодын хүчирхийллийг нухацтай авч үздэг гэж хохирогчид хариулжээ. Эндээс харахад цагдаагийн алба хаагчид сэтгэл санааны хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл (хүчиндэхээс бусад) болон эдийн засгийн хүчирхийллийн бусад хэлбэрийг (хохирогчийг ажил эрхэлж, бие даан орлого олохыг нь хориглох замаар эдийн засгийн хараат байдлыг нь ашиглах) зөрчил эсвэл гэмт хэрэгт татаж шийтгэж болох талаар зохих мэдлэг ойлголтгүй байх хандлагатай байна.

Мөн гомдол бүртгэх үед цагдаагийн алба хаагчид ГБХТХ-ийг эшлэхгүй (дээр дурдсан 4 хэлбэрийн хүчирхийллийг гэр бүлийн хүчирхийлэл хэмээн иж бүрэн хуульчилсан цорын ганц хууль) Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуулийг л баримтлах, хандлагатай байна. Практикт зөвхөн Зөрчлийн тухай хуулийг баримтлах, гэр бүлийн хүчирхийллийн ихэнх

хэрэг зөрчлөөр бүртгэгддэгийг дээр дурдсан. Судалгаанд оролцсон дийлэнх хохирогчийн хариулснаар цагдаагийн байгууллага зарим хэргийг (тухайлбал, хүчирхийлэгч архи, согтууруулах ундаа хэрэглээгүй, цохиж зодоогүй ч хохирогчийг байнга үгээр доромжлон, хардаж сэрдэж, мөшгиж, хянаж цагдах) бүртгэхээс татгалзсан байна. Мэдээллийн санд бүртгэгдсэн сэтгэл санааны болон эдийн засгийн хүчирхийлэлтэй холбоотой хэргүүдийн тоо маш бага байгаа нь хохирогчийн хариултыг баталж байна. Улмаар хууль сахиулах байгууллагын алба хаагчид гэр бүлийн хүчирхийллийн эдгээр хэлбэрийг ГБХТХ-д эсрэгээр нь заасныг үл харгалзан гэр бүлийн хүчирхийлэл гэхээс илүүтэй ихэвчлэн гэр бүлийн зөрчил, үл ойлголцол хэмээн буруу ойлгосон хэвээр байгааг илтгэж байна. Үүнээс үзэхэд ГБХТХ болон түүнд заасан хүчирхийллийн хэлбэрийн талаар цагдаагийн алба хаагчийн ойлголт, мэдлэг сул байна. Судалгаанд хамрагдсан байгууллагууд дундаас цагдаагийн байгууллагынхны ГБХТХ-ийн хэрэгжилт хангалттай эсэх талаарх хариулт харилцан адилгүй, хамгийн их зөрүүтэй байсныг онцлох нь зүйтэй. Учир нь нэг хэсэг нь тус хуулийн хэрэгжилтийг маш хангалтгүй гэж үзэх хандлагатай байхад нөгөө хэсэг нь хуулийн хэрэгжилтийг хангалттай (гэвч судалгаанд хамрагдагсдын дөнгөж 2.9 хувь) гэж хариулсан цор ганц бүлэг юм. Хууль сахиулах байгууллагын алба хаагчид гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хуулиудын 20 гаруй хувийг практикт ашиглаж байгаа гэж үзэж байгааг уг судалгаагаар тогтоосон.

Хөрөнгө мөнгөний хангалтгүй байдал нь цагдаагийн мөрдөн шалгах ажиллагаанд саад болж байгаа төдийгүй мөрдөн шалгах ажиллагаа нь хохирогчийн сэтгэл зүйн эмгэгт мэдрэмжтэй, хохирогч төвтэй байж чадахгүй байна.

Эргүүлийн цагдаа гэр бүлийн хүчирхийллийн дуудлагаар очиж зохих арга хэмжээ, байцаалт мэдүүлэг авч болдог гэсэн утгаараа цагдаагийн бүх алба хаагч гэр бүлийн хүчирхийллийн хэрэг дээр ажилладаг хэдий ч дээд боловсрол эзэмшсэн, хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах эрх бүхий мөрдөгч мөрдөн шалгах ажиллагаа явуулж шийдвэр гаргадаг. Гэр бүлийн хүчирхийллийн хэргийг мөрдөн шалгаж байгаа цагдаагийн алба хаагчид нь ганцхан гэр бүлийн хүчирхийллийн хэрэг дээр ажилладаггүй тул тэд ажлын ачаалал, шийдвэрлэх хэрэг ихтэй байдаг. Энэ байдал нь мөрдөн байцаалтын чанар, үр нөлөөнд сөргөөр нөлөөлж байна. Цагдаагийн байгууллагаас хэрэг бүртгэлтийн анхан шатны ажиллагааг зохих хугацаанд

нь явуулдаг боловч ихэнх тохиолдолд 5 хоногийн хугацааг 14 хоног болгон сунгадгийг энэхүү судалгаагаар тогтоосон. Хэдийгээр энэ нь Эрүүгийн хуулийн 30.7 дугаар зүйлд заасан хуулийн хугацаанд багтаж байгаа ч гэр бүлийн хүчирхийллийн хэргийг үйлдэгч нь үргэлж тодорхой байдаг гэж үзэхэд (сэжигтнийг илрүүлэх, баривчлах, нотлох баримт цуглуулах) мөрдөн шалгах үйл явц харьцангуй удаан байна.

Цагдаагийн алба хаагч мэдүүлэг авахдаа гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн хэрэгцээ шаардлагыг анхаарч үзэхгүй байна.

Мөрдөн байцаалтын шатанд хохирогчийг цагдаагийн хэлтэст аваачиж, мэдүүлэг авдаг ба энэ нь хохирогчид хүндрэл бэрхшээл дагуулах нь бий. Юуны түрүүнд, цагдаагийн алба хаагчид гол төлөв эрэгтэй хүмүүс байдаг бөгөөд гэр бүлийн хүчирхийллийн мэргэшүүлэх сургалтанд хамрагдаагүй байх нь түгээмэл. Дэлхийн олон орны соёлд байдагтай нэгэн адилаар хохирогчдын дийлэнх хувийг эзэлдэг эмэгтэйчүүд нь гэр бүлийн хүчирхийллийн зарим төрлийн мэдээллийг эсрэг хүйсийн хүнд ярихад хүндрэл учирдаг. Ийм байдал нь ялангуяа бэлгийн хүчирхийлэл зэрэг нүдэнд харагдах нотлох баримт эсвэл ил гэмтэл байхгүй, гэр бүлийн хүнийг хүчиндэх гэмт хэргийг хуулиар зүйлчилсэн хэдий ч нийгэмд гэмт хэрэг гэж үзэхгүй хэвээр байгаа хүчирхийллийн зарим төрөлд хамаарна. Түүнчлэн, цагдаагийн хэлтэст мэдүүлэг өгөх тусгай өрөө байхгүй байгаа нь ялангуяа бэлгийн хүчирхийллийн хохирогчдын яриа бусдад сонсогдох, чөлөөтэй ярихад хүндрэлтэй байдаг. Зарим хэлтэст тусгайлсан өрөө байгаа боловч хохирогч бусдын өмнө цагдаагийн алба хаагчийг корридорт хүлээх, хүмүүсээс ичиж зовох бэрхшээл тулгардаг гэж хариулжээ. Түүнчлэн тэргэнцэртэй хүн нэвтэрч орох зам, коридор, тасалгаа, дохионы хэлний орчуулагч байлцуулах зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хохирогчдод зориулсан тусгай үйлчилгээ байхгүй нь нийтлэг байна.

Цагдаад хандсан гэр бүлийн хүчирхийллийн гомдлын 20 хүрэхгүй хувь нь л мөрдөн байцаалтын шатанд хүрдэг.

Цагдаагийн байгууллагад 2019 онд гэр бүлийн хүчирхийллийн тухай 57,749 гомдол ирснээс зөвхөн 8,962 үйлдэлд зөрчлийн хэрэг үүсгэж хянан шалгасан бол 8,788 тохиолдлыг эрүүгийн хэрэг байдлаар мөрдөн шалгасныг ЦЕГ-ын мэдээллийн сангаас харж болно. Эдгээр тоо баримт нь Улсын ерөнхий прокурорын газар (УЕПГ)-ын мэдээллийн сангийн мэдээллээс

(10,143 хэргийг зөрчил, 6,043 хэргийг эрүүгийн хэргээр тус тус шалгасан) зөрөөтэй байна. Хэдийгээр тоон статистик бага хэмжээний зөрөөтэй ч цагдаа, прокурорт нийт гомдлын 20 хүрэхгүй хувийг шалгаж байгаа нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдлын дийлэнхийг хэрэг бүртгэлт хийж, шалгадаггүй нь эдгээр мэдээллийн сангаас тодорхой харагдаж байна. Цаашилбал, цагдаагийн байгууллага гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол хүлээн авснаас хойш гэмт хэрэг эсвэл зөрчил эсэхийг тогтооход дунджаар 19.4 хоног зарцуулж байгаа хуульд заасан хугацаанд багтаж байгаа боловч эзэн холбогдогч нь тодорхой хэргийг хэтэрхий удаан шалгаж байгааг харуулж байна.

Энэхүү судалгаагаар гэр бүлийн хүчирхийллийн ихэнх тохиолдол хэрэг хянан шийдвэрлэх үе шатыг бүрэн дамжихгүй тасалдаж байгаа талаар шалтгааныг бүрэн тогтоох боломжгүй ч зарим таамаглал дэвшүүлсэн. Нэгдүгээрт, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.4 дүгээр зүйлийн дагуу эрх бүхий албан тушаалтан зөрчлийг хялбаршуулсан журмыг ашиглан хэргийг шийдвэрлэдэгтэй холбоотой байх боломжтой. Хоёрдугаарт, хохирогч шүүх эмнэлгийн дүгнэлт гаргуулаагүй (хол зай, замын зардал, эмнэлгийн төлбөр төлөх боломжгүй, хүүхэд харах хүнгүй гэх мэт амьдралын бусад асуудал) нөхцөл байдал шалтгаалсан. Гуравдугаарт, хүчирхийлэгчийн дарамтанд өртсөн болон бусад шалтгаанаар хохирогч гомдлоо буцааж авахыг хүсэх, анх цагдаад хандаж мэдүүлсэн мэдүүлгээ буцах зэрэг. Эдгээр шалтгаан нь юу байхаас үл хамааран асуудалд прокурорын байгууллага хяналт тавьж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

Хохирогчид цагдаагийн авч буй арга хэмжээнд сэтгэл дундуур байгаа ч тулгарч буй хүчирхийллийг даруй зогсоох өөр арга мэдэхгүй байна.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн зүгээс цагдаагийн байгууллагад хандаж гаргасан гомдол, шалгасан хэргүүдийн хувь хэмжээ бага байгаа нь хохирогч гэр бүлийн хүчирхийллийн талаарх өөрийнх нь гомдлыг цагдаагийн байгууллага нухацтай авч үзэхгүй гэсэн ойлголт, хүлээлттэй холбоотой байх боломжтой байна. Учир нь цагдаагийн алба хаагч нь ихэнх тохиолдолд хохирогчдод хамгийн эхэнд харагддаг хууль зүйн тогтолцооны төлөөлөл байдаг билээ. Гэтэл цагдаагийн байгууллагад гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлсэн хохирогчдын 70 гаруй хувь нь “нэлээд сэтгэл хангалуун бус” эсвэл “сэтгэл хангалуун бус” гэж хариулжээ. Өргөн утгаар нь аваад

үзвэл ийм хэмжээнд сэтгэл дундуур байгаагийн гол шалтгаан нь цагдаагийн алба хаагчид хохирогчдод хэрхэн хандсан хандлагатай холбоотой. Хохирогчдийн дийлэнх нь цагдаагийн алба хаагчийг найрсаг бус, өөрийнх нь асуудалд туслахгүй байх гэсэн айдастай байх ба үүнээс үүдэн хэргээ шийдвэрлүүлэх дургүй байдаг. Мөн хохирогчид цагдаа нар тэдэнтэй зохих ёсоор зөвлөн тусалж харьцдаггүй, тэднийг үл хүндэтгэсэн, ялгаварлан гадуурхсан байдлаар харьцдаг, хохирогчийн нийгэм-эдийн засгийн байдал буюу хөрөнгө чинээг нь харж харьцдаг гэж үздэг байна. Судалгаанд хамрагдсан гурван хохирогч тутмын хоёр нь цагдаад хандсан ч ердөө 18 хувь нь дэмжлэг “сайн” авсан гэж хариулсныг энд дурдах нь зүйтэй. Гэвч энэ бүхнээс үл хамааран судалгаанд хамрагдсан хохирогчдын бараг 40 хувь нь хүчирхийллийг даруй таслан зогсоох өөр арга байхгүй тул дахин цагдаа дуудна гэж мэдэгджээ. Энэ судалгаанаас харахад цагдаагийн байгууллагад хандсан иргэдийн 60.7 хувь нь 1-2 удаа, 12.6 хувь нь 3-6 удаа хандаж байсан байна.

Цагдаагийн алба хаагч хохирогч төвтэй хандлагыг мөрдүүлж, цахим сан ашиглах, төрийн бусад үйлчилгээтэй нягт холбоотой ажиллахгүй байна.

Цагдаагийн алба хаагч гэр бүлийн хүчирхийллийн хэргээр 2 удаа Зөрчлийн тухай хуулиар баривчлах шийтгэл эдэлж байсан этгээдийг цахим сангаас шүүж мэдээд 3 дахь удаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн талаар гомдлыг нэгтгэн өөрийн санаачлагаар Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад зааснаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шалгасан 1 тохиолдол байгаа нь хангалттай үзүүлэлт биш байна. Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн бүртгэлийн АСАП цахим санг хангалттай ашиглахгүй байна. Түүнчлэн Иргэний бүртгэл, шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн зэрэг бусад төрийн байгууллагаас хохирогчийн гаргуулан авдаг зарим төрлийн мэдээллийг хүнд сурталгүй, хохирогчид чирэгдэлгүй болгож төрийн байгууллагууд уялдаа холбоотой хамтран ажиллах чиг үүргийн хүрээнд шийдвэрлэхгүй байна. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг төрийн байгууллагуудаас янз бүрийн мэдээлэл бүрдүүлж авчрахыг шаардах нь зардал их гаргах, олон дахиж явуулах, залхаан чирэгдүүлж гомдлоосоо татгалзах, оргон зайлахад ч хүргэдэг байна.

2. ПРОКУРОР

Монгол Улсад прокурор хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоонд чухал үүрэг гүйцэтгэж цагдаа, шүүхийн хоорондох гол зангилаа болдог. Гэвч хуулийн байгууллагын бусад салбарынхны нэгэн адилаар нийгмийн соёлд ууссан байх хандлагатай. Тийм болохоор тэд гэр бүлийн хүчирхийлэл нь гэр бүлийн дотоод асуудал гэж үзэх хандлага байсаар байна. Ийм хандлагыг арилгахын тулд зарим улс хохирогч зөвшөөрч-хамтарч ажиллах эсэхээс үл хамааран прокурор гэр бүлийн хүчирхийллийн хэргийг нарийн мөрдөж, эцсийг нь хүртэл шалгах боломжийг олгодог прокурорын “нэг ч хэргийг орхигдуулахгүй” бодлогыг баримталж эхлээд байна. Уг бодлого нь хүчирхийлэл үйлдэгч болон нийгэмд ийм хүчирхийллийг хүлээн зөвшөөрөхгүй, амархан мултарч чадахгүй гэсэн санааг түгээн ойлгуулах зорилготой. Монгол Улсад ГБХТХ-ийн 14 дүгээр зүйлд зааснаар прокурор хохирогчоос хараат бусаар мөрдөн шалгах, яллах ажиллагааг үргэлжлүүлэх боломжийг олгодог. ЭБШТХ-ийн 25.1 дугаар зүйлд заасан “Яллагдагч, шүүгдэгч нь Эрүүгийн хуульд заасан хөнгөн гэмт хэргийг анх удаа үйлдсэн бөгөөд учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан нөхцөлд хохирогч нь яллагдагч, шүүгдэгчтэй сайн дураараа эвлэрсэн бол хэргийг хэрэгсэхгүй болгоно.” гэсэн заалт хүчингүй болж, хохирогч гомдлоо буцаасан ч гэр бүлийн хүчирхийллийн хэргийг прокурор мөрдөн шалгах, яллана. Гэсэн хэдий ч бодит байдалд ялангуяа гомдлоо буцаан авсан гэж хариулсан хохирогчдын тоо их, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг прокурорын шатанд очихгүй байгаа тоон статистик өндөр байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой нийт зөрчил ба гэмт хэргийн 50 хүрэхгүй хувь нь прокурорын шатанд шилждэг.

УЕПГ-ын мэдээллийн сангаас үзвэл 2019 онд зөрчлийн 10,143 (нийт 57,749) хэрэг бүртгэгдсэнээс 5,002 нь шүүхэд шилжсэн бол тус онд эрүүгийн хэрэг үүсгэн бүртгэсэн 6,043 хэргийн 774 хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж¹², мөн 1,007 хэрэг нь шүүхэд шилжсэн байна. Энэ нь прокурорын түвшинд ч бас хэрэгт ял шийтгэхгүй хаах явдал их байгаа бөгөөд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой зөрчлийн зөвхөн 50 орчим хувь нь, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой эрүүгийн хэргийн 30

¹² Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр батлуулахаар шүүхэд хүргүүлсэн гэм буруутайгаа хүлээсэн зөвшөөрч, шийтгэл хөнгөлүүлэхийг хүссэн мэдэгдэл. Мэдээллийн сангийн шинжилгээнээс харахад ихэвчлэн хөнгөн гэмтэлтэй тохиолдолд ашиглагддаг.

орчим хувь нь л шүүхийн байгууллагад шилжсэн байна. Хаагдсан хэрэгт хийсэн дүн шинжилгээгээр нийт хэргийн дийлэнх буюу дөрвөн зөрчил тутмын гурав нь зөрчлийн бүрэлдэхүүнгүй/шинжгүй, эсвэл Эрүүгийн хуульд хамаарна хэмээн үзэж хаасан бол таван хэрэг тутмын нэг нь хөөн хэлэлцэх хугацаа (зөрчлийн хэргийн хувьд 6 сар) дууссан тул хэрэгсэхгүй болгосон байна. Энэхүү судалгааны хүрээнд асуулга авсан гэр бүлийн хүчирхийллийн 120 хохирогчоос зөвхөн 34-ийнх нь хэрэг прокурорын газраас шүүхэд шилжсэн байна. Энэ хохирогчдын 56.1 хувь нь тэдний хэрэг зөрчлийн хэрэг байсан, 26.8 хувь нь эрүүгийн хэрэг, 17.1 хувь нь мэдэхгүй хэмээн хариулжээ.

Прокурорын мөрдөн шалгах үйл ажиллагаа удаан үргэлжилдэг, шийдэгдэхгүй уддаг нь хохирогч дахин гэр бүлийн хүчирхийлэлд өртөх эрсдэлийг бий болгодог.

Прокуророос хэргийг үргэлжлүүлэн шалгах шийдвэр гаргасан хэдий ч хянан шалгах үйл ажиллагаа удаашрах нь бий. Ингэхдээ зөрчил эсвэл гэмт хэргийн аль нь болохоос хамаарч хугацааны хувьд ялгаатай байдаг. Хавтаст хэргийн судалгаанаас үзэхэд зөрчлийн хэрэг дундажаар 5.3 хоногийн дараа шүүхэд шилжиж, прокурор хэргийг хүлээн авснаас хойш 11.4 хоногийн дараа шүүх хурал товлогдсон болохыг тогтоожээ. Энэ хугацаа богино байгаа нь нотлох баримтын шаардлага бага байгаатай холбоотой байх талтай. Харин гэмт хэргийн хувьд эсрэгээрээ нэлээдгүй хугацаа зарцуулсан нь тогтоогдсон. Тухайлбал, прокурор эрүүгийн хэрэг нээснээс шүүх хурал хүртэл дунджаар 122.7 хоног зарцуулдаг байна. Үүнд цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэлт дунджаар 19 орчим хоног (хуулиар зөвшөөрөгдсөн уртасгасан хугацаанд), прокурорын нэмэлт мөрдөн байцаалтад дунджаар 73 хоног, улмаар анхны шүүх хурал хүртэл ойролцоогоор 25 хоног зарцуулж байгаа нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг дээрх хугацаанд дахин хүчирхийлэлд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Прокурор гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид аюулгүй байдлын болон сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг бараг хэрэглэхгүй байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 21.2 дугаар зүйлийн дагуу прокурор нь хэрэг бүртгэлт болон мөрдөн байцаах шатанд хохирогчдыг нэн даруй хамгаалалтад авах зорилгоор хамгаалалтын арга хэмжээг

хэрэглэх шийдвэр гаргаж болно. Үүнд аюулгүй байдлын болон сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ багтах ба хохирогчийг аюулгүй, нууцлал бүхий түр хамгаалан байршуулах үйлчилгээгээр (хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв) хангах, эрх зүйн туслалцаа, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх зэрэг багтана. Түүнчлэн хүчирхийлэл үйлдэгч этгээдэд ЭХХШТХ-ийн 4.1 дүгээр зүйлийн 2.9 дэх хэсэгт зааснаар таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хугацааг сунгах саналыг шүүхэд хүргүүлэх эрхтэй. Мөн тус хуулийн 13.1 дугаар зүйл нь хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах талаарх прокурорын эрх мэдлийг нэмэгдүүлсэн. Статистик судалгаанаас авч үзэхэд 2019 онд прокуророос зөвхөн 13 хэрэгт л хамгаалалтын арга хэмжээ авах шийдвэр гаргасаны 6 нь гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг байсан. Хамгаалалтын арга хэмжээг маш ховор хэрэглэдэг болохыг хавтаст хэргийн судалгаагаар мөн тогтоосон. Тухайлбал, уг судалгаанд авч үзсэн 139 хэргийн зөвхөн нэгд нь л прокурор хамгаалалтын арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн байна.

Хохирогчийг хамгаалах арга хэмжээг тусгасан хуулиуд хэрэгжихэд хүндрэлтэй байна.

Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд прокуророос хамгаалах арга хэмжээ хэрэглэх хүсэлт гаргахад анхаарч үзэх хүчин зүйлсийг (тухайлбал, хохирогчийн эрсдэл, аюулгүй байдал, орчин нөхцөл, шүүх эмнэлгийн баримт, төлөвлөж буй арга хэмжээний зардал) тодорхойлсон байдаг. ЭХХШТХ-ийн 8.4 дүгээр зүйлд хохирогч аюулгүй байдлаа хамгаалуулах хүсэлт гаргах эрхийг хуульчилсан боловч Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн 19.1-т гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирч болзошгүй хангалттай үндэслэл байгаа, эсхүл хохирол учирсан бол хамгаалуулах эрх үүснэ гэсэн байна. Эдгээр хуулийн заалтууд нь хүчирхийлэлд өртсөн, өртөх эрсдэлтэй, хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай бүх хохирогчдод зориулагдсан боловч хэт ерөнхий, өндөр шаардлага шаарддаг, шаардлага хангахгүй бол хамгаалуулах эрхээ эдлэх боломжгүй, гэр бүлийн хүчирхийллийн нарийн төвөгтэй харилцааг харгалзан үзээгүй тул гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод тохиромжгүй болохыг судалгаагаар тогтоосон. Дээрх асуудал нь прокурор хамгаалах арга хэмжээ хэрэглэсэн хэргийн тоо маш бага байдаг шалтгаантай холбоотой байх боломжтой. Нөгөөтээгүүр, хамгаалалтын арга хэмжээ хэрэглэхтэй холбоотой заалтуудын талаарх хохирогчийн мэдлэг бага, тус арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн

боломж төрийн байгууллагуудад хомс, хүн хүчний нөөц дутагдалтай байдагтай холбоотой. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Мэдээллийн сангаас харахад 2019 онд 1121 хохирогчид хамгаалах байрны үйлчилгээ үзүүлсэн боловч эдгээр хохирогчийн хэдэн хувь нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн болох нь тодорхойгүй байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад таслан сэргийлэх арга хэмжээ авах ажиллагаа дутагдалтай байна.

ГБХТХ болон ЭХХШТХ-ийн 14 дүгээр зүйлд заасны дагуу прокурор, цагдаагийн алба хаагч нь яллагдагч, шүүгдэгчид хувийн баталгаа гаргах, барьцаа авах, хүчирхийлэл үйлдэгчийг баривчлах зэрэг ажиллагаа явуулахаар хуульчилсан. Харин хуулийн дагуу тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, хязгаарлалт тогтоох, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг шүүхээс оногдуулна. Эдгээр таслан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох ажиллагааны зорилго нь хохирогчийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх үндсэн ач холбогдолтой. Гэсэн хэдий судалгаанаас харахад 2019 онд хязгаарлалт тогтоох 429 шүүгчийн захирамж гарсны 33 нь л гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг байсан төдийгүй нийт хүчирхийлэл үйлдэгчдийн дөнгөж 21.23 хувьд нь оногдуулжээ. Түүнчлэн 2019 онд гэр бүлийн хүчирхийллийн 201 хэрэгт цагдан хорих захирамж гаргасан нь шүүхэд шилжсэн нийт хэргийн 9.95 хувийг, зөрчлийн улмаас 1132 саатуулах эрх хязгаарлах арга хэмжээ авсан нь шүүхэд шилжсэн ийм төрлийн хэргийн 13.31 хувийг тус тус эзэлж байна. Энэхүү статистик нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдэд цагдаа, прокурор, шүүх таслан сэргийлэх арга хэмжээг авах талаар холбогдох хуулийн заалтыг хэрэгжүүлэх мэдлэг, чадвар, хүсэл эрмэлзэл дутмаг байгааг нотолж байна. Энэ нь хохирогч хуулийн байгууллагад хандах, ялангуяа хуулиар олгогдсон хамгаалалт авах нөхцөл байдалд сөргөөр нөлөөлж байна гэсэн дүгнэлтэд хүрлээ. Хамгаалалтын арга хэмжээ хэрэглэсэн зарим тохиолдолд хэрэгжилт нь үр дүн муутай байгаа нь арга хэмжээг хэрэгжүүлэх журам, санхүүжилт дутмаг байдалтай мөн л холбоотой байна.

Хохирогчид хуулийн байгууллагууд, ялангуяа прокурорын чиг үүргийн талаар мэдлэг дутмаг, итгэх итгэл доогуур байна

Энэхүү судалгаагаар гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид хэрэг хянан шийдвэрлэх тогтолцооны талаарх мэдлэг дутмаг, хуулийн байгууллагад итгэх итгэл маш доогуур байгааг тогтоосон. Судалгаанд хамрагдагсдаас цагдаа, прокурор, шүүхэд итгэх итгэлийн түвшинг нь судлахад прокурорын байгууллагын талаар “мэдэхгүй/хариулт байхгүй гэсэн хариултыг хамгийн их хувьтай өгчээ. Ерөнхийдөө, цагдаагийн байгууллагын талаарх мэдлэг, тэдэнд итгэх итгэлийн түвшин (прокурор, шүүхтэй харьцуулахад) өндөр байх хандлагатай байгаа боловч нийт оролцогчдын дунд тэдний гомдлыг шийдвэрлэхэд прокурор ямар үүрэг оролцоотой болохыг ойлгоогүйгээс гадна өөрийнх нь гомдлын дагуу үүсгэсэн хэрэг нь зөрчил эсвэл гэмт хэргийн аль болох талаарх ойлголт дутмаг, хэрхэн шийдвэрлэснийг мэдэхгүй байх тохиолдол байна. Хохирогч цагдаа дуудаж, хүчирхийлэл үйлдэгчийг баривчилж, хэд хоног саатуулсан тохиолдолд судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь шүүхээс баривчлах шийтгэлийг оноосон гэж бодож байв. Гэвч судалгаанд оролцогч хохирогчдын хувьд цагдаа, прокурор, шүүхийн талаарх мэдлэг маш хязгаарлагдмал, туршлага багатай байгаа нь тэдний асуултанд хариулснаас тодорхой байна. Хохирогчийг прокурорын шатанд хэн төлөөлснийг асуухад 47 хувь нь мэдэхгүй гэж хариулсан бол 41.1 хувь нь өөрийгөө өмгөөлсөн, 14.7 хувь нь өмгөөлөгч өмгөөлсөн гэж хариулжээ.

3. ШҮҮХ

Шүүгч гэр бүлийн хүчирхийллийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх эцсийн чухал үүрэг гүйцэтгэдэг. Эрүүгийн болон зөрчлийн хэргийг шүүн таслах ажиллагааг гүйцэтгэхдээ шүүгч хохирогчийг хамгаалж, хүндэтгэж, яллагдагчийг шударгаар шүүж, гэм буруутай нь тогтоогдсон этгээдэд зохих ял, шийтгэл оногдуулах үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, шүүгч өөрийн шийдвэрээр эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх явдал нь нийгэмд үл хүлээн зөвшөөрөгдөх сөрөг үзэгдэл төдийгүй Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиар ял, шийтгэл хүлээх гэмт хэрэг, зөрчил гэдгийг хүчирхийлэл үйлдэгч болон олон нийтэд харуулдаг.

Монгол Улсад шүүгч гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой бүртгэгдсэн арван хэрэг тутмын хоёрыг хянан шийдвэрлэдэг.

Монгол Улсын хэмжээнд 2019 онд цагдаагийн байгууллагад гэр бүлийн

хүчирхийллийн 57749 гомдол мэдээлэл ирснээс 1521 хэргийг эрүүгийн хэргээр шийдвэрлэсэн бол зөрчлийн хэргээр шийдвэрлэсэн хэргийн тоо 9181 байв. Харин фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцсон 120 хүнээс ердөө 23-ынх нь хэрэг шүүхийн шат хүртэл явсан байна. Энэ нь нийтдээ 10702 хэрэг буюу гэр бүлийн хүчирхийллийн нийт гомдол мэдээллийн 20 орчим хувийг шүүхийн шатанд шилждэг гэсэн үг юм.

Гэр бүлийн хүчирхийллийн гомдол мэдээлэл шүүхээр шийдвэрлэгдэх хувь нь маш бага (ялангуяа гэмт хэргийн тухайд) байгаагийн нэг шалтгаан нь Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан хүчирхийлэл нь “байнгын” байх ёстой гэсэн шинжээс шалтгаалсан байх талтай. Өөрөөр хэлбэл, шүүгчид гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой “байнга” гэсэн хуулийн заалтын талаар нэгдсэн ойлголтод хүрээгүйн зэрэгцээ нөгөө талаас цагдаагийн алба хаагчид, прокурор зэрэг хэрэг хянан шийдвэрлэх тогтолцооны бусад хуульчдын адилаар шүүгчдийн дунд эрэгтэйчүүд давамгайлсан, тэд гэр бүлийн хүчирхийллийн талаар уламжлалт үзэлтэй байх магадлалтай гэж судлаачид таамаглал дэвшүүлсэн. Фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцогчид хүчирхийлэл үйлдэгч өмнө нь гурван удаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн байхыг шаардаж байгааг буруу, байнга гэсэн үйлдлээс үл хамааран Эрүүгийн хуулийг хэрэглэх шаардлагатайг онцолж байлаа.

Хохирогч гомдол гаргахаас хэргийг шүүхээр хэлэлцэх хүртэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашралтай байна.

Гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны хугацаа нь хэргийн онцлог, шинжээс хамааран харилцан адилгүй байж болох ч цагдаагийн байгууллагад гомдол мэдүүлснээс анхан шатны шүүхэд хүрэхэд 122.7 орчим хоног болдог тухай дээр өгүүлсэн. Энэ нь цагдаагийн мөрдөн байцаалт, прокурорын хяналт, шүүхээр хянан шийдвэрлэх зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрт удаашралтай байгааг илтгэж байна. Ийнхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дөрвөн сар үргэлжилж, удаашрах нь хохирогчид ихээхэн үр дагавартай. Тухайлбал, хүчирхийлэл үйлдэгч эсвэл ар гэрийнхний зүгээс эвлэрэхийг шаардах нь гомдлоо буцаах, сэтгэл санааны хямралд ороход хүргэдэг. Мөн хэрэг шийдвэрлэлт ийнхүү удаашрах нь дахин хүчирхийлэлд өртөх, зарим тохиолдолд амь насаа алдах эрсдэлийг нэмэгдүүлж болох юм.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдэд оногдуулдог хамгийн түгээмэл шийтгэл нь баривчлах бөгөөд энэ нь гэр бүлийн хүчирхийлэл дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд үр нөлөөгүй байна.

Гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн ихэнх хувь буюу 97.67 хувь (2019 онд)-д Эрүүгийн шүүхээс хүчирхийлэл үйлдэгчид баривчлах шийтгэл, үлдсэн хувьд (2.33 хувь) нь торгох шийтгэл оногдуулсан гэсэн тоон мэдээ байна. Торгох шийтгэл оногдуулах үед ихэвчлэн хохирогч торгуулийг төлдөг болохыг уг судалгаагаар тогтоосон. Түүнчлэн фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцогчид баривчлах шийтгэлийн хугацаа дунджаар 7-30 хоног үргэлжилдэг хэмээн хариулсан. Зан үйлд нөлөөлөх сургалтад албадан хамруулж байгаа ч энэ хөтөлбөрт хүчирхийлэл үйлдэгч дөнгөж 8-25 цаг оролцогийг хохирогчид хангалтгүй гэж үзжээ. Түүнчлэн фокус бүлгийн хэлэлцүүлгийн оролцогчид баривчлах шийтгэл нь ихэвчлэн хүчирхийлэл үйлдэгчийг өс санахад хүргэдэг төдийгүй суллагдаж ирээд гэр бүлийн хүчирхийлэл дахин үйлдэгдэх вий гэсэн айдастай амьдрахад хүргэдэг гэж хариулжээ. Энэхүү судалгааны хүрээнд ярилцлага авсан гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын үзэж байгаагаар шүүх, хуулийн байгууллага шийтгэхээс илүүтэй урьдчилан сэргийлэх, хүмүүжүүлэх арга хэмжээнд голлон анхаарах хэрэгтэй, учир нь одоо хэрэглэгдэж буй шийтгэлийн арга хэмжээ нь хүчирхийлэл үйлдэгчийг уурлуулж, өс санахад хүргэдэг, эцсийн дүндээ хүчирхийлэл давтагдах, илүү ноцтой болоход нөлөөлдөг байна. Иймд гэр бүлийн хүчирхийллийн хэрэг зөрчилд албадан болон сайн дурын сургалт, нийтэд тустай ажил, зорчих эрхийг хязгаарлах, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авах зэрэг нийгэмд суурилсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, ялангуяа яллагдагчийн зан үйлийг дотоод мөн чанараас нь засаж залруулах нь цээрлүүлэхээс үр нөлөөтэй байх талтай байна. Үнэндээ гэр бүлийн хүчирхийллийн ихэнх хохирогчид шүүн таслах ажиллагааны эцсийн үр дүнд хүчирхийлэгчийн зан үйл засрахыг л хүлээсэн байх нь элбэг байдаг.

Хохирогчдод шүүхийн үйл явцын талаар хангалттай мэдээлэл өгдөггүй.

Хохирогчид цагдаагийн байгууллагыг гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэдэг хуулийн байгууллагын гол төлөөлөл гэж үзэх хандлагатай нь судалгаагаар тогтоогдсон бөгөөд энэ нь ихэнх хохирогч хэрэг хянан

шийдвэрлэх ажиллагааны үе шатыг бүрэн дамжаагүй цагдаагийн байгууллага дээр асуудлаа шийдвэрлүүлсэнтэй холбоотой байна. Өөрөөр хэлбэл, дээр дурдсан прокурорын үүргийн талаар ойлголт дутмаг байгаатай адил хохирогчид нь шүүхийн үйл явцын талаар маш бага мэдлэгтэй байна. Үүнээс гадна шүүхээс хохирогчдод шүүн таслан ажиллагааны үйл явцын талаарх мэдээллийг тогтмол, хангалттай өгдөггүй. Фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцсон хүмүүсээс таван хохирогч тутмын нэг нь (26 хувь) шүүх хуралдааны товыг мэдээгүй бөгөөд товын талаар мэдсэн хүмүүс нь голчлон цагдаагийн байгууллагаас санамсаргүй байдлаар олж мэдсэн байна. Түүнчлэн хохирогчид шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх үеэр хүчирхийлэл үйлдэгч этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авсан эсэхийг мэдээгүй байсан.

Хохирогчид хууль ёсны эрх, тэр дундаа өмгөөллийн туслалцаа авах эрхийн талаар мэдлэг муутай байна.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид эрх зүйн туслалцаа авах эрх, хохирол нэхэмжлэх эрх, сэтгэл зүйн дэмжлэг авах эрх зэрэг хууль ёсны эрхийнхээ талаар маш бага эсвэл огт мэдэхгүй байна. Үүний үр дүнд тэд эрхээ эдлэх, эдгээр дэмжлэгийг авах хүсэлт гаргахгүй байх тохиолдол өндөр хувьтай. Энэхүү судалгаагаар фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцогчдын 70.7 хувь нь өмгөөлөгчөөр дамжуулан эрх зүйн туслалцаа авах боломжийн талаар мэдэхгүй, өөр эх үүсвэрээс энэ мэдээллийг авч байгаагүй гэж хариулсан байна. Үүнээс шалтгаалан хохирогчид шүүхийн хянан таслах ажиллагааны явцад эрх зүйн туслалцааг бүрэн ашиглаж чадахгүй байх хандлагатай бөгөөд үндсэндээ ийм боломжит хувилбар байгааг урьдаас мэдээгүй, эсвэл түүнтэй холбоотой зардал нь их байсантай холбоотой байна. Хэдийгээр тэд өмгөөлөгчтэй байх нь шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх явцад илүү аюулгүй, зохих мэдээлэлтэй байна гэдгийг тодорхой мэдэж байсан ч маш цөөн хохирогч хэрэг нь шүүх хуралдаанаар хэлэлцэгдэхээс өмнө өмгөөлөгчийн туслалцаа авсан. Үлдсэн хохирогчийн хувьд ерөнхийдөө шүүн таслах үйл ажиллагаа, тэр дундаа шүүх хуралдаан таагүй дурсамж болсон, тэд бэлтгэлгүй, ямар ч хамгаалалтгүй, сэтгэл санааны хувьд ихээхэн дарамттай байснаа илэрхийлсэн.

4. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БУСАД БАЙГУУЛЛАГУУД

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид нь зөрчил, эсвэл эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн шалгаж байгаа эсэхээс үл хамааран олон тооны үйлчилгээ авах эрхтэй. Үүнд: хамгаалах байраар хангуулах, нийгмийн халамж, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах, сэтгэл зүйн зөвлөгөө, хүүхэд хамгаалал, хууль зүйн зөвлөгөө, эрхийнхээ талаар мэдээлэл авах зэрэг багтдаг бөгөөд эдгээр үйлчилгээг ИНБ, ТББ, нутгийн захиргааны байгууллагууд голчлон үзүүлдэг. ГБХТХ-ийн 34 дүгээр зүйлд хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор хамгаалах байранд байрлуулах, нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх зэрэг хохирогчийг хамгаалах үйлчилгээг үзүүлэхээр хуульчилсан. Мөн гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээ (тухайлбал, эрх зүйн туслалцааны зардал) үнэ төлбөргүй байхаар заасан. Гэвч шаардагдах санхүүжилт, талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой заахгүйгээр эдгээр үйлчилгээ нь цаасан дээр оршиж, хохирогчдын амьдралд хэрэгжихгүй байх нь түгээмэл байна.

Хохирогч эдлэх эрх, авах боломжтой үйлчилгээний талаар мэдээлэл авах боломж хомс, тэдэнд зориулсан “Тусламжийн зурагт хуудас”-аар хангагдахгүй байна.

Цагдаагийн алба хаагчид гэр бүлийн хүчирхийллийн хэрэг гарсан газарт бараг л хамгийн түрүүнд очдог. ГБХТХ-ийн 25.4 дүгээр зүйлийн дагуу цагдаагийн алба хаагч гэр бүлийн хүчирхийллийн үйлдлийг таслан зогсоох зорилгоор орон байранд нь нэвтэрч, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээ, эрхийн талаар мэдээллийг бичгээр өгч болно. Энэхүү заалтыг хэрэгжүүлэх үүднээс ЦЕГ-аас гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээлэл, түүний тодорхойлолт, хэлбэр, холбогдох зөрчлийн болон эрүүгийн хуульд заасан хохирогчийн эрхийн талаарх мэдээлэл, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үнэ төлбөргүй үзүүлэх үйлчилгээний жагсаалтыг агуулсан “Тусламжийн зурагт хуудас”-ыг гаргажээ.

Гэсэн хэдий ч цагдаагийн алба хаагч нь тусламжийн зурагт хуудас болон түүнд агуулагдаж буй мэдээллийг өгөх үүргийг албан ёсоор хүлээгээгүй тул орон нутгийн цагдаагийн нэгж тухайлбал өөрийн үзэмжээр зурагт хуудсыг өөрчлөх эсвэл бүр ашиглахаас зайлсхийх боломжтой. Судалгаагаар цагдаагийн алба хаагч тусламжийн зурагт хуудас өгөхийг заавал мөрдөх ёстой хуулийн шаардлага гэхээсээ илүү зөвлөмж гэж үздэгийг тогтоожээ.

Иймд орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ИНБ, ТББ-ууд гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт нийгмийн үйлчилгээ, туслалцаа үзүүлж байгаа ч ярилцлагад хамрагдсан олон хохирогч энэ талаар мэдлэггүйн улмаас үйлчилгээг хүртэж чадаагүй байна.

Нийгмийн ажилтнууд зохих сургалтад хамрагдах нь тааруу, ажлын ачаалал ихтэй байдаг.

2002 оноос хойш нийгмийн ажилтан мэргэжлээрээ ажиллахын тулд шаардлагатай мэргэжлийг эзэмшиж, эрхийг авах зорилгоор төрийн өмчийн эсвэл хувийн их дээд, сургуульд суралцаж, дээд боловсрол эзэмшихийг шаарддаг болсон. Их дээд сургууль төгсөж, бэлтгэгдсэн нийгмийн ажилтнууд нь дүүрэг, аймаг зэрэг төвийн бүсэд ажиллах нь элбэг бөгөөд харин сум, баг, хорооны түвшинд нийгмийн үйлчилгээний чиглэлээр ажиллаж буй олонх алба хаагч нь нийгмийн ажилтны мэргэжлээр суралцаагүй байдаг. Өөрөөр хэлбэл, нийгмийн ажилтны хүний нөөц, боловсон хүчний хомсдол хөдөө орон нутагт байсаар байна. Түүнээс гадна хамтарсан багт нийгмийн үйлчилгээний ажлыг ихэвчлэн хамтарсан багийн нарийн бичиг болон нийгмийн ажилтан гүйцэтгэдэг бөгөөд гэтэл тухайн алба хаагч нь өөрөө төрийн захиргааны олон ажлыг давхар хариуцаж ажилладаг тул анхаарал, халамж хангалттай хандуулах цаг, боломж муутай байгаа нь ажиглагдлаа. Нийгмийн ажилтан гэлтгүй хамтарсан багийн бусад гишүүдийг ч мөн адил чадавхижуулах, ажлын ачааллыг тохируулах, тогтвор суурьшилтай ажиллуулах боломж, бололцоогоор хангах хэрэгцээтэй байна. Одоогоор ажиллаж буй хамтарсан багуудын тухайд гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлыг тогтооход хангалттай мэдлэг, ур чадваргүй, ажиллах цаг хугацаа багатай, төсөв зардал нь шийдэгдээгүй гэх мэт асуудлууд тулгамдаж байна.

Хамтарсан багийн үйл ажиллагааг илүү нарийн тодорхойлж өгөх нь зүйтэй. Ингэснээр гишүүдийн үүрэг, хариуцлага тодорхой болох юм.

ГБХТХ-ийн 20.1 дүгээр зүйлд зааснаар хамтарсан баг нь өрхийн эмч, сум, хороо, сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд энэ нь цагдаагийн алба хаагчид эмч, нийгмийн ажилтан, мэргэшсэн бусад байгууллагын төлөөлөлтэй хамтран ажиллах боломжийг олгодог. Гэсэн хэдий ч хамтарсан багийн

талаарх хуулийн заалт, холбогдох дүрэм журманд тодорхойгүй асуудлууд байсаар байна. Тухайлбал, орон нутгийн түвшинд сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтны аль нь хамтарсан багт орох тухай тодорхой заалт байхгүй. Гэтэл эдгээр 3 төрлийн нийгмийн ажилтан нь 3 өөр байгууллагад харьяалагддаг албан тушаалтан юм. Цаашлаад зарим бүс нутагт өрхийн эмч байхгүйгээс хамтарсан баг эмчгүй байх, улмаар тус хамтарсан багийн эрүүл мэндийн бүрдэл хэсэг нь хариуцах эзэнгүй орхигдож болзошгүй байдалд хүрдэг. Түүнээс гадна ТББ-ын ажилчдыг “шаардлагатай үед” татан оролцуулж болно гэж дүрэм, журамд заасан байдаг тул хамтарсан багт тэднийг оруулахгүй байх нь ч түгээмэл. Дээрх бүрэлдэхүүний асуудлаас гадна хамтарсан багийн гишүүдийн ажил үүргийн хуваарилалт мөн тодорхойгүй нөхцөл байдалтай юм. Түүнчлэн, зарим тохиолдолд хамтарсан багийн гишүүдэд ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэл бий. Учир нь цөөн хүн амтай орон нутагт хамтарсан багийн гишүүд хохирогч эсвэл хүчирхийлэл үйлдэгчийг эсвэл хоёуланг нь таньдаг байх тохиолдол гарч байсан.

Хамгаалах байрны үйлчилгээ, нэг цэгийн үйлчилгээний төвүүдийг өргөтгөж, хүн хүч, хөрөнгө санхүүжилтийг нь сайжруулах шаардлагатай байна.

Монгол Улсад 2020 оны 11 дүгээр сарын байдлаар аймаг бүрт нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх 15 төв, орон даяар 20 хамгаалах байр үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод эрүүл мэндийн үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, хамгаалалтын үйлчилгээ (хамгаалах байр гэх мэт) зэрэг нэн чухал үйлчилгээ үзүүлдэг. Дээр дурдсан 35 хамгаалах байр болон нэг цэгийн үйлчилгээний төвийн 22 нь орон нутгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамаарах байх 13 нь ИНБ-д харьяалагддаг. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 35 хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв нь хоногт нийт 367 орчим хүн хүлээн авах хүчин чадалтай. Гэвч бодит байдал дээр хүн хүч, хөрөнгө санхүүгийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан бүрэн хүчин чадлаараа ажиллахад хүндрэлтэй байна. Энэхүү судалгаагаар 2019 онд “хамгаалах байрны үйлчилгээ”-г (“аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын бусад үйлчилгээ”-ээс гадна) 1121 удаа үзүүлсэн байна. Энэ тоо зөвхөн гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод хамаарахгүй ба гэр бүлийн хүчирхийллийн бүх хохирогч нарт хамгаалах байрны үйлчилгээ хүртээмжтэй байсан эсэх нь тодорхойгүй

байна. Хэдийгээр судалгаанд хамрагдсан олон хохирогч өмнө нь хамгаалах байранд амьдарч байсан ч гэлээ судалгаа хийх үед маш цөөхөн хохирогч (5 буюу 5-аас бага хувь нь) хамгаалах байранд байсан нь үүнийг баталж байна. Үүнээс гадна, Монгол Улсад хамгаалах байр болон нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах шаардлагатай газрууд нэлээд байна.

Хуулийн байгууллагууд болон төрийн бусад байгууллага, ТББ-уудын уялдаа холбоо хангалтгүй, тэдгээрийн хамтын ажиллагааг үр дүнтэй болгох хэрэгцээ шаардлага байна.

Монгол Улсад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон бусад төрийн байгууллагууд хуулиар тогтоосон өөрсдийн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд өөрт хамаарах хэсгийг л хариуцан ажиллаж байгаа нь гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хамтарсан ажиллагаа, уялдаа холбоо муутайг харуулж байна. Энэ нь гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт хохирогч төвтэй хандлагыг бэхжүүлэхэд сөргөөр нөлөөлж, хохирогчийн эрх зүйн байдлыг дордуулж байна. Тухайлбал, хохирогчдын үзэж байгаагаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат болгонд олон удаа (хамгаалах байранд, цагдаагийн мөрдөн байцаагчид, дараа нь прокурор, эмч, өөр цагдаагийн мөрдөн байцаагч гэх мэт) мэдүүлэг өгч, ихэвчлэн ижил баримт, үйл явдлуудыг давтан ярих шаардлагатай тулгардаг. Энэ тохиолдол бүрт хохирогчийн сэтгэл зүйд хямрал үүсч, стресс, депрессэнд өртдөг цөөнгүй хохирогч хариулжээ. Цагдаагийн албаны тухай хуульд цагдаагийн хэлтэс, нэгж, албан хаагчид өөр хоорондоо хамтран ажиллах талаар заасан байдаг ч төрийн бусад байгууллага, ИНБ, ТББ-тай хэрхэн хамтран ажиллах талаар дурдаагүй. Ярилцлагад хамрагдсан хохирогчид нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ өөрсдөд нь ихээхэн ач холбогдолтой байсныг онцолж байв. Ингэснээр хохирогчид өөр өөр дэмжлэг, үйлчилгээ авахын тулд олон газрын хаалга татаж, цаг зав, мөнгө, эрч хүчээ гарздах шаардлага гараагүй нь давхар дарамтанд өртөөгүй гэдгийг дурдаж байна.

ЗӨВЛӨМЖ

- I. **Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийллийн шинжийг бүрдүүлж буй “байнга” гэх ойлголтын нэр томъёоны тодорхойлолтыг Эрүүгийн хуулиар тодорхойлох.** Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн бүрэлдэхүүнд “байнга” гэх ойлголтыг хэрхэн тодорхойлох нэг мөр ойлголтгүй байгаа нь практикт хуульчдын дунд эргэлзээтэй байдлыг төрүүлж, ихэнх гэмт хэрэг зөрчлөөр зүйлчлэгдэж, хүчирхийлэл үйлдэгчийн хүлээх хариуцлагыг бууруулж, хохирогчийг эрсдэлд оруулж байна. Зөрчлийн тухай хуулиар оногдуулж буй шийтгэл нь хэт хөнгөн учраас хүчирхийлэгчийг дахин хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход үр нөлөөгүй байна.
- II. **Зөрчлийн тухай хуульд заасан хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, бусадтай харилцахыг хязгаарласан гэсэн 2 үйлдлийг Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд нэмж оруулах.** Түүнчлэн ГБХТХ-д заасан сэтгэл санааны ба эдийн засгийн хүчирхийллийн хэлбэрүүдийг Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд нарийвчлан тусгах. ГБХТХ-ийн агуулгад “хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан ” гэдгийг сэтгэл санааны хүчирхийлэлд багтаасан бөгөөд үүнийг хэрхэн ойлгох талаар дэлгэрэнгүй тайлбарлах нь зүйтэй. Тухайлбал, олон улсад “албадан хяналтандаа байлгах” гэсэн ойлголтыг хохирогчийг гэмтээх, шийтгэх, айлгах зорилгоор биед нь халдах, бэлгийн харьцаанд албадах, заналхийлэх, доромжлох, сүрдүүлэх болон хүчирхийллийн бусад аргыг ашиглах үйлдэл эсвэл давтагддаг үйлдлүүд гэж үзэх ба түүнчлэн хохирогчийг тусламж авах боломжтой хүнээс тусгаарлах, нөөц боломжийг нь хувийн ашиг сонирхлын үүднээс мөлжин ашиглах, хохирогч өөрийгөө авч явах, эсэргүүцэх, зугтахад шаардлагатай хөрөнгө мөнгөгүй байлгах, өдөр тутмын үйл хөдлөлийг нь хянах замаар хохирогчийг дуулгавартай, хүчирхийлэгчээс хамааралтай байлгахад чиглэсэн олон төрлийн үйлдэл багтана” хэмээн тодорхойлдог байна.
- III. **Гэр бүлийн гишүүд, хамаатан, хамт амьдардаггүй хүмүүсийг хуулийн үйлчлэлд хамруулахын тулд ГБХТХ болон Эрүүгийн холбогдох хууль тогтоомжид заасан тодорхойлолтуудыг уялдуулах.** Эрүүгийн хуульд “гэр бүлийн хамаарал бүхий харилцаа” гэж гэр бүлийн гишүүд, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаа, гэрлэлт нь цуцлагдсан,

бусад шалтгаанаар хамт амьдарч байгаад больсон хүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа хүн, тэдгээрийн асрамжид байгаа хүмүүсийн хоорондын харилцааг ойлгоно” гэсэн бол ГБХТХ-д илүү өргөн хүрээтэйгээр гэр бүлийн хамаарал бүхий харилцааг тодорхойлсон нь давуу талтай болжээ. Иймд Эрүүгийн хуулийн 10.4 дүгээр зүйлд заасан тайлбарыг 11.7 дугаар зүйл рүү шилжүүлэх, түүнчлэн ГБХТХ-ийн агуулгаар өргөжүүлэн томьёолох нь зүйтэй.

- IV. Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд гэр бүлийн хүчирхийллийн бусад хэлбэр болох сэтгэл санааны, эдийн засгийн, бэлгийн хүчирхийллийн төрлийг нэмж хуульчлах. Ингэснээр ГБХТХ-ийн хэрэгжилт үр нөлөөтэй болж, эдгээр хуулиудын хоорондох “хуулийн цоорхой” арилж хүчирхийлэл үйлдэгч ял завших явдлыг бууруулна.** Одоогийн байдлаар ГБХТХ-д заасан гэр бүлийн хүчирхийллийн олон төрлийн үйлдлийг Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд заагаагүй нь хуулийн цоорхой үүсгэж, улмаар хүчирхийлэл үйлдэгч ял шийтгэл хүлээхгүй эсвэл хөнгөн шийтгэл хүлээж байна.
- V. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, таслан сэргийлэх захирамж гаргахад шүүх эмнэлгийн нотолгоо шаардлагагүй талаар тодорхой заалт оруулж, ГБХТХ болон ЭХХШТХ-д нэмэлт өөрчлөлт оруулах.** Шүүх эмнэлгийн магадлагаа авах нь хохирогчид хүндрэлтэй, төлбөрийн чадваргүйн улмаас хийлгэх боломжгүй зэрэг олон асуудлыг дагуулж байна. Түүнчлэн практикт шүүх эмнэлгийн дүгнэлт гаргуулаагүй тул хэрэг үүсгэхээс татгалзсан болон шүүх таслан сэргийлэх арга хэмжээ авах шийдвэр гаргаагүй байж болзошгүй нөхцөл байдал судалгаагаар илэрсэн.
- VI. Аюулын зэргийн үнэлгээ нь таслан сэргийлэх арга хэмжээ авах үндсэн нөхцөл биш болохыг тодорхой заах.** Шүүхээс эрсдэлийн үнэлгээг шаарддаг. Өөрөөр хэлбэл, ял шийтгэл оногдуулахад хувийн байдлыг нь харгалзан үзнэ гээд Эрүүгийн хуульд заасан тул шүүх аюулын зэргийн болон эрсдэлийн үнэлгээ заавал шаарддаг. Гэвч хамтарсан багийн ажлын хүрээнд цагдаа, нийгмийн ажилтан хамтран уг үнэлгээний маягтыг бөглөхийг шаарддаг тул процессын саад бэрхшээл дагуулдаг байна. Бодит байдалд эдгээр алба хаагч байнга хамтран ажилладаггүй, маягтыг цаг тухайд нь бөглөдөггүй нь хохирогчид хамгаалалтын арга хэмжээг цаг алдалгүй авахад нь саад болдог.

- VII. Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдалд дуудлага өгсөн тохиолдолд “хуурамч” дуудлага, мэдээлэл өгөх зөрчилд үл хамаарах талаар Зөрчлийн тухай хуульд онцгойлон нэмэлт өөрчлөлт оруулах.** Гэр бүлийн хүчирхийллийн гомдол мэдээллийн дуудлагын тухайд худал дуудлага зөрчил хамаарахгүй тухай заах нь зохистой. Учир нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогч өөрийн эсрэг чиглэсэн хүчирхийллийг даруй таслан зогсоохын тулд нэн түрүүнд цагдаа дууддаг боловч цагдаа нар хүчирхийлэл үйлдэгчийг баривчлах, эсвэл түр хугацаагаар саатуулах хуулийн заалтыг мэддэггүй. Иймээс цагдаагийн алба хаагч саатуулахаар авч явах үед хохирогч гомдлоо буцааж авах хүсэлт гаргаж, өгсөн мэдүүлгээ буцах нь түгээмэл тохиолддог. Энэ үед цагдаагийн алба хаагч хохирогчийг хуурамч дуудлага мэдээлэл өгсөн гэж торгох үндэслэлтэй. Энэ байдал нь хохирогчийг шийтгэж, хохирогч, гэрчийн аль аль нь хүчирхийллийн талаар мэдээлэхээс татгалзахад хүргэдэг.
- VIII. Шүүгч хохирогчид санхүүгийн нөхөн төлбөр, хүүхдийн тэтгэлэг олгуулах, хүүхдийн асран халамжлах эрхийг түр хугацаагаар олгох захирамж гаргах боломж бүрдүүлэхийн тулд ГБХТтХ болон холбогдох бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах.** Мөн шүүгчийн зүгээс хүчирхийлэл үйлдэгч гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогчийн төлсөн торгууль болон бусад хохирол, түүний дотор эмчилгээний зардал, алдсан орлого, замын зардал, хувийн эд хөрөнгөд учирсан хохирлыг хохирогчид нөхөн төлөх захирамж гаргахыг зөвшөөрдөг байх нь зүйтэй.
- IX. Хохирогч (төлбөрийн чадваргүй) хууль зүйн зөвлөгөө болон өмгөөллийн үйлчилгээг үнэ төлбөргүй авах талаар Хууль зүйн туслалцааны тухай хуульд тусгах.** Хохирогч зөрчлийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль зүйн туслалцаа авах нь нэн чухал бөгөөд энэ нь хохирогчийг дахин эрсдэлд орох, хүчирхийлэгчид таслан сэргийлэх арга хэмжээ авхуулах, хууль зүйн бусад боломжийг эдлэх талаарх хохирогчийн боломжийг эрс нэмэгдүүлнэ.
- X. Гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн хэргийг хянан шалгах явцад хүчирхийлэгчийг саатуулах болох бусад хязгаарлах арга хэмжээ авах боломжийг хуульчилсан.** Үүний зэрэгцээ гэр бүлийн байранд очихыг хориглосон буюу хохирогчийн байгаа газарт ирүүлэхгүй байх (Эрүүгийн хуульд заасан тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах заалт байдаг) тухай Зөрчлийн тухай хуульд

нэмэлт оруулах. Энэхүү заалт нь гэр бүлийн хүчирхийлэгчийг гэр бүлийн байранд ирэх, тодорхой зайнд ойртохыг хориглохын зэрэгцээ хохирогч орон байрандаа байх эрхийг онцгойлон олгох боломжийг олгоно. Энэ нь тодорхой хугацаатай (тухайлбал эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хугацаанд) байж болно. Түүнчлэн, шүүхээс хязгаарлах арга хэмжээний хугацааг (жишээ нь 6-12 сар) сунгадаг байдлаар зохицуулах боломжтой.

- XI. Зөрчил, гэмт хэргийн зүйлчлэл, оногдуулж байгаа ял, шийтгэлийн төрөл зэргээс үл хамааран хохирогчийг хамгаалалтын арга хэмжээгээр хангах тухай эрх зүйн зохицуулалтыг бий болгох.** Хамгаалалтын арга хэмжээний талаарх шүүгчийн захирамж нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогчтой харилцахыг хориглох, хохирогчид санхүүгийн дэмжлэг түр хугацаанд үзүүлэх, тусламжийг нэн даруй үзүүлэх шүүхийн захирамжийг хүлээн авах боломжийг хохирогчид олгох үр дүнтэй. Дэлхийн улсуудад ийм боломжийг олгох нь хохирогчийг хамгаалах захирамж нь хугацаа алдалгүйгээр, эрүүгийн шүүх хуралдаанаас ихэвчлэн шаарддаг нотлох баримтын дарамтгүйгээр нэн даруй гардаг онцлогтой байдаг.
- XII. Хэргийг шийдвэрлэх ажиллагааны шаардлагатай мэдээллийг ямар хугацаанд хохирогчид ямар алба хаагч мэдэгдэх үүрэгтэйг холбогдох хуулиудад тодорхой болгож, хуульчлан заах.** Үүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг түр саатуулах газраас сулласан тухай хохирогчид мэдэгдэх зэрэг бөгөөд ингэснээр хохирогч өөрийгөө хамгаалах, сэтгэл зүйн бэлтгэлтэй байх зэрэг давуу талыг олгох юм.
- XIII. Албадан сургалтын санхүүжилтийг нэмэгдүүлэх, сургалтын агуулга, стандарт, хөтөлбөрийг шинэчлэх, сэтгэл зүй, зан үйлд нөлөөлөх хүртээмжийг нэмэгдүүлэх талаар анхаарах.** Албадан сургалтын үр нөлөөг сайжруулах нь гэр бүлийн хүчирхийлэгчийн зан үйлд нөлөөлөх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх.
- XIV. Торгох шийтгэл нь хохирогчид давхар дарамт болдог эрх зүйн зохицуулалтаас татгалзах.** Гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт торгох шийтгэл, ял оногдуулах нь хохирогч тэрхүү торгуулийг хүчирхийлэгчийн өмнөөс төлж барагдуулах нь түгээмэл тул хохирогчийг давхар шийтгэдэг тогтолцоо Монгол Улсад үйлчилж байна.

ЗУРГИЙН ЦОМОГ



ОУЭЗХБ-ын Хөтөлбөрийн менежер А.Жаргалан судалгааны товч тайлангийн хэлэлцүүлгийн үеэр судалгааны зорилго, хамрах хүрээ, судлаачдыг танилцуулж байгаа нь.



Судалгааны товч тайлангийн хэлэлцүүлэгт оролцож буй (зүүн гар талаас) Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн Г.Нарантуяа, Канад Улсын ЭСЯ-ны Хөгжлийн мэргэжилтэн Б.Оюунбилэг, ХЗДХЯ-ны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга Л. Нянгэрэл, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын Суурин төлөөлөгч Стивен Кент, Канад Улсын ЭСЯ-ны Хөгжлийн хөтөлбөрийн тэргүүн Гленн Зизански нар.



Судалгааны багийн ахлах, Доктор, Б.Одонгэрэл судалгааны танилцуулга, гол үр дүн, зөвлөмжийг танилцуулж байгаа нь.



Судалгааны товч тайлангийн хэлэлцүүлэгт оролцож буй хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл.



Судалгааны баг Ховд аймгийн прокурорын газарт ажиллаж байгаа нь.



Бүлгийн ярилцлага хариуцсан судлаач Ш.Солонгын удирдан явуулж буй фокус бүлгийн ярилцлагын үеэр.



Судалгааны баг Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн хэлтэст ажиллаж байгаа нь.



Баримт бичиг, мэдээллийн сан хариуцсан судлаач Г.Түвшинжаргал фокус бүлгийн ярилцлагын үеэр.